



Шүүхийн өнөөгийн нөхцөл байдлын тандалт судалгаа

Гүйцэтгэсэн: З.Баянсүрэн
(Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвийн
Социологич-судлаач)

АГУУЛГА

График, хүснэгтийн жагсаалт.....	2
Оршил	7
Судалгааны зорилго, судалгааны арга зүй.....	8
Арга зүй	9
Судалгааны түүвэр	10
Шүүгчээс авсан судалгааны үр дүн	11
Прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нараас авсан судалгааны үр дүн	36
Шүүхийн захиргааны албан хаагчдаас авсан судалгааны үр дүн.....	49
Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч нараас авсан судалгааны үр дүн.....	62
Шүүхэд хандаж байсан олон нийтээс авсан судалгааны үр дүн.....	66
Шүүхэд хандаж байгаагүй олон нийтээс авсан судалгааны үр дүн	77
Хууль зүйн сургуулийн оюутнуудаас авсан судалгааны үр дүн	84
Дүгнэлт	89
Зөвлөмж	93



ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Графикийн жагсаалт

График 1. Судалгаанд оролцогчдын нас хувиар, судалгаанд оролцсон шүүгчийн байршил тоогоор.	12
График 2. Шүүгчээр ажилласан жил	12
График 3. Албан тушаал	12
График 4. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа дараах үйл ажиллагаатай санал нийлж буй эсэх	13
График 5. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг харуулав	16
График 6. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг албан тушаал тус бүрээр	16
График 7. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг шүүгчээр ажилласан жилээр	17
График 8. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг шүүгчдийн насны бүлгээр	18
График 9. Шүүгчийн ёс зүй ба хариуцлага, хараат бус байдалтай холбоотой бодомжид санал нийлж байгаа эсэх	19
График 10. Шүүгчид сахилгын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөх талаарх заавар, зөвлөмж, аргачлал хангагдсан эсэх	20
График 11. Шүүгчдийн ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд ямар ажлыг нэн яаралтай хийх ёстой болохыг харуулав	20
График 12. Шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдын дараах асуудлын алийг нь илүү анхаарч ажиллах ёстой вэ?	22
График 13. Шүүхийн захиргааны ажилчдын ажлаас гарч байгаа шалтгаан (n=196 давхардсан утга=686)	26
График 14. Дараах шүүхийн байгууллагатай холбогдох бодомжуудтай санал нийлэх үү?	26
График 15. Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбогдох бодомжуудтай санал нийлэх үү?	27
График 16. Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбогдох бодомжуудтай санал нийлэх үү? Ажилласан жилээр харьцуулан харвал.	27
График 17. Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбогдох бодомжуудтай санал нийлэх үү? Ажилласан жилээр харьцуулан харвал.	28
График 18. ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг	28
График 19. ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг гэсэн сонголтыг албан тушаалаар харьцуулан харвал.	28
График 20. Таны хувьд ямар хэлбэрээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргэж буюу албаны мэдээллүүдийг илүү хурдан шуурхай, оновчтой байдлаар Танд хүрэх вэ?	29
График 21. Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна бэ? Насны бүлгээр харьцуулан харуулав.	29
График 22. Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна бэ? Ажилласан жилээр харьцуулан харуулав.	30
График 23. Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна бэ? Албан тушаалаар харьцуулан харуулав.	30

График 24. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?	30
График 25. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?	31
График 26. Та аль шатны шүүхэд ажилладаг вэ?	33
График 27. Та дараах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс аль төрөл дээр ажилладаг вэ?	34
График 28 . Ажлын байдал:	36
График 29. Таны бодлоор шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл хэр үр дүнтэй явагдаж байна гэж бодож байна вэ?	36
График 30. Хэрэв та үр дүнгүй болон огт үр дүн гараагүй гэсэн хариултыг сонгосон бол өөрийн харилтын шалтгааныг бичнэ үү.....	36
График 31. Та манай шүүгчдийн ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвар, харилцааны ур чадвар, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн үнэлэх вэ?.....	38
График 32. Хэрэв та дээрх асуултад муу, маш муу гэж хариулсан шалтгаанаа бичнэ үү.....	38
График 33. Та дараах шүүгчтэй холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?.....	40
График 34. Таны бодлоор шүүгчдийн ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд аль бодомж дээр илүү анхаарч ажиллах ёстой вэ?	41
График 35. Та манай улсын шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг эсэхийг үнэлнэ үү.	42
График 36. Та дараах шүүхийн байгууллагатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?	42
График 37.Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-тэй холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?.....	43
График 38.Та дараах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?	43
График 39. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?	44
График 40. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ? /Давхардсан тоогоор 229 хариултыг 100 хувь гэж үзэн шинжилгээ хийв./	46
График 41. Олон нийтийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ? /Давхардсан тоогоор 179 хариулт байна./	46
График 42. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд хэр зэрэг нээлттэй, ил тод байдаг вэ?	47
График 43 . Албан тушаал:.....	49
График 44. Аль шатны, ямар хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд ажилладаг вэ? Давхардсан утгаар	49
График 45. Оролцогчдын нас болон ажилласан жилийг харуулав.	50
График 46. Таны бодлоор шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл хэр үр дүнтэй явагдаж байна гэж бодож байна вэ?	50
График 47. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудтай Та санал нийлэх үү?	50
Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа үндсэн 5 ажлаас шүүхийн цахимжилтын ажил хамгийн үр дүнтэй хэрэгжиж байна. График 48. Хэрэв та дээрх бодомжуудтай санал нийлэхгүй байвал. Яагаад санал нийлэхгүй байгаа шалтгаанаа энд бичнэ үү.	51
График 49. Та дараах шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?	51
График 50. Та дараах шүүгчтэй холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?.....	52

График 51. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?	53
График 52. Та дараах шүүхийн захиргааны ажилчидтай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?	53
График 53. Та дараах удирдлагатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?.....	54
График 54. Таны бодлоор захиргааны ажилчдын ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд аль бодомж дээр илүү анхаарч ажиллах ёстой вэ?	55
График 55. Таны бодлоор захиргааны ажилчдыг чадавхжуулахын тулд аль бодомж дээр илүү анхаарч ажиллах ёстой вэ?	55
График 56. Таны бодлоор шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарт ямар төрлийн хэрэг маргаан хамгийн их ачаалал үүсгэдэг вэ?	56
График 57. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?	59
График 58. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?	60
График 59. Хэдэн сарын өмнө шүүх хуралд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон бэ?, Шүүх хуралд оролцоход ямар нэгэн асуудал гарсан уу?	62
График 60. Шүүхийн ажилтнуудын харилцаа, хандлагын үнэлгээг харуулав.....	62
График 61. Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны шийдвэртэй бүрэн санал нийлсэн эсэхийг болон Иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцсоноор шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдлэг нэмэгдүүлсэн эсэхийг харуулав.....	63
График 62. Иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож байсан иргэдэд ямар нэгэн асуудал тулгарахад шүүхэд хандах эсэхийг харуулав.....	63
График 63. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?	63
График 64. Сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг дан тоололтоор болон хэдийн сарын өмнө шүүх хуралд ШХИТ-өө сууж байсан хугацаагаар харьцуулан харуулав.....	64
График 65. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд хэр зэрэг нээлттэй, ил тод байдгийг харуулав.....	64
График 66. Таны нас:	66
График 67. Таны ажил эрхлэлтийн байдал.....	66
График 68. Таны боловсролын түвшин:	66
График 69. Аль шатны шүүхэд хандаж байсан бэ? <i>Давхардсан утгаар</i>	67
График 70. Та ямар төрлийн хэрэг маргаанаар шүүхэд хандсан бэ? <i>Давхардсан утгаар</i>	67
График 71. Та шүүх хуралдаанд ямар үүрэгтэй оролцсон бэ?	67
График 72. Таны хувьд шүүхэд хандахад Таны шүүхэд итгэх итгэлийг бууруулсан тохиолдол гарч байсан уу?	68
График 73. Ямар төрлийн хэрэг маргаанаар аль шатны шүүхийн үйлчилгээ Таны шүүхэд итгэх итгэлийг багасгаж байсан вэ? /Хэдэн сонголт ч хийж болно/ n=56.....	68
График 74. Тухайн үед Таны шүүхэд итгэх итгэл буурахад нөлөөлсөн хүчин зүйлс:	69
График 75. Тухайн үед асуудлыг ямар байдлаар, ямар аргаар шийдвэрлэсэн бол та сэтгэл хангалуун үлдэх байсан бэ?	69
График 76. Таны хандсан шүүх Таны асуудлыг хэдий хугацаанд шийдвэрлэж өгсөн бэ?	70

График 77. Таны хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн тухайн шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд нарийвчилсан үнэлгээ өгнө үү?.....	70
График 78. Шүүхийн ажилтнуудын зан харилцааны соёлыг Та үнэлнэ үү.....	70
График 79. Шүүх нь таны үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэр хамгаалж байна гэж бодож байна вэ?.....	71
График 80. Шүүхэд хандахад Танд ямар нэгэн бэрхшээл үүсэж байсан уу?.....	71
График 81. Дараах бэрхшээлүүдээс Таны хувьд хамгийн их асуудал үүсгэж байсан бэрхшээлийг сонгосон уу.....	72
График 82. Сүүлийн хоёр жилийн хугацаанд шүүхийн байгууллагын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдөж байна вэ?	73
График 83. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ? N=282	73
График 84. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?	74
График 85. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?	74
График 86. Шүүхээр үйлчлүүлэхэд шаардлагатай лавлагаа, мэдээллийг цахимаар авч байсан уу?	75
График 87. Хэрэв тийм бол лавлагаа мэдээллийг цахимаар авахад хэр боломжийн санагдсан бэ?	75
График 88. Судалгаанд оролцогчдын нас.....	77
График 89. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин	77
График 90. Таны хувьд шүүхэд хандах ямар нэгэн асуудал гарч байсан уу?	78
График 91. Тийм бол та шүүхэд хандсан уу? N=51	78
График 92. Та ямар асуудлаас болоод шүүхэд хандаагүй вэ? n=16.....	79
График 93. Таны бодлоор манай улсын шүүгчид ёс зүйн хэм хэмжээг хэр зэрэг сахидаг вэ?	79
График 94. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?	79
График 95. Таны бодлоор шүүх нь таны үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэр хамгаалж байна гэж бодож байна вэ?.....	80
График 96. Та шүүхийн үйл ажиллагаа болон шүүгч нартай холбоотой мэдээллийг хэр их хангалттай мэдээлэл авдаг вэ?	80
График 97. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд хэр зэрэг хангалттай, ил тод байдаг вэ?	80
График 98. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?	81
График 99. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?	82
График 101. Судалгаанд оролцогчдын нас, Та хэд дүгээр курсийн оюутан бэ?	84
График 102. 3. Та ямар салбар эрх зүйгээр мэргэшиж, мэргэших бодолтой байна вэ?	84
График 103. Шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр нөлөөлж байгаа эсэх:	85
График 104. Шүүх нь таны үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаалж чадаж байгаа эсэх:	85
График 105. Шүүхийн тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байсан оюутнуудын хувьд: n=12	86
График 106. Шүүхийн Тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаагүй оюутнуудын хувьд: n=23	87

График 107. Шүүхийн тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаагүй оюутнуудын хувьд: шүүхийн удирдлага, Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн Ерөнхий газар (ШШГЕГ) холбоотой дараах асуудлуудад өөрийн үнэлгээг өгнө үү. n=23 87

График 108. Та шүүхийн үйл ажиллагаа болон шүүгч нартай холбоотой мэдээллийг хэр их хангалттай мэдээлэл авдаг вэ? 88

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудтай санал нийлэхгүй байгаа шалтгаануудыг харуулав. 14

Хүснэгт 2. Шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдад тулгарч буй асуудлуудыг хүснэгтээр харуулав. 24

Хүснэгт 3. Шүүгч нарт ямар төрлийн хэрэг маргаан хамгийн их ачаалал үүсгэдэг гэж бодож байна вэ? 25

Хүснэгт 4. Иргэд ямар мэдээлэлтэй байвал Танай байгууллагын үйл ажиллагаа илүү хурдан шуурхай, ойлгомжтой болно гэж бодож байна вэ? 32

Хүснэгт 5. Таны хувьд нийт шүүгчдийн чуулганаар та ямар асуудлыг хэлэлцүүлээсэй гэж бодож байна вэ?..... 32

Хүснэгт 6. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй талаарх саналд нэг удаа давтагдаж буй саналыг харуулав..... 59

Хүснэгт 7. Оюутан Таны бодлоор манай улсын шүүх эрх мэдлийг хараат бус, бие даасан тогтолцоог бүрдүүлэхийн тулд юуг өөрчилбөл илүү сайжрах вэ? 85



2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болох Монгол Улсын шүүхийн тухай хууль (цаашид ШТХ гэнэ)-ийн зорилтод “Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тусгасан.

Дээр дурдсан зорилтыг хангаснаар иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх хангагдаж, шүүх эрх мэдэл, түүний хараат бус байдалд хэн нэгэн нөлөөлөх, эрх мэдэл тогтоохоос сэргийлж, олон талын оролцоо, хяналт тэнцлийг бий болгоход чиглэсэн байна.

Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороотой байхаар тус хуульд тусгаж, эрх үүргийг тодорхойлсон байна.

Түүнчлэн Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг сонгохдоо ил тод сонгон шалгаруулах зарчмыг баримтлах, нийтийн сонсгол хийх, нэр дэвшигчдийн талаар иргэд санал бодлоо илэрхийлэх замаар шударга ёсыг хангах, шүүхэд шатлан дэвших зарчмыг хэрэгжүүлэх шинэ тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн юм.

Нийтийн сонсгол бол аливаа асуудлыг иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор нээлттэй хэлэлцэж, ил тод байдлыг хангахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургаадугаар зүйлд заасан ард түмний мэдэх эрх, оролцоог хангаж буй чухал зохицуулалт болсон байна.

Түүнчлэн шүүгчид нэр дэвшигчээс хууль зүйн мэдлэг, чадварын шалгалт төдийгүй мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалт авах, эдгээр шалгалтын аль алинд нь тэнцэж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг шүүгчээр томилохоор заажээ.

Эдгээр өөрчлөлт хэрэгжсэнээр шүүх болон шүүгчийн хараат бус байдал хангагдаж, улс төр болон бизнесийн аливаа нөлөөлд орохоос сэргийлэх нөхцөл бүрдэж шударга, ардчилсан нийгэм тогтооход ШТХ чиглэж, батлагдсанаас хойш хоёр жил болсон байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид ШЕЗ гэх) нь шүүхийн шинэтгэлийн үр дүнг тандан судлах зорилгоор “Шүүхийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа”-г хийв.

Энэхүү судалгаагаар шүүх эрх мэдлийн шинэтгэлийн явцад тулгарч буй асуудлуудыг тодорхойлж, тухайн асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, бодлогын түвшинд шинэчлэл хийн улмаар шүүх эрх мэдлийн шинэтгэлийн үр нөлөөг тандах зорилгоор зорилтод 7 бүлгээс судалгааг авч судалгааны хүрээнд дүгнэлт, санал зөвлөмж гаргах зорилготой юм.

Тус судалгааны зорилгын хүрээнд дараах 7 хэмжигдэхүүний хүрээнд судалгааг явуулав.

1. Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал
2. Шүүхийн нээлттэй ил тод байдал
3. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл
4. Шүүхийн дэд бүтэц, нөөц
5. Шүүгчийн ёс зүй ба хариуцлага
6. Шүүхийн үр ашигтай үйл ажиллагааны зохион байгуулалт
7. Шүүхийн цахимжилт

Судалгааны асуулгын төрөл

Тус 7 хэмжигдэхүүний хүрээнд зорилтод 7 бүлгийг эх сурвалж болгохдоо бүлгийн онцлогийг харгалзан дараах төрлийн асуулгаар мэдээллийг цуглуулсан юм.

1. Шүүгчээс авах асуулга
2. Экспертүүд буюу хуульч, өмгөөлөгч болон хууль зүйн сургуулийн багш нараас авах асуулга
3. Шүүхийн захиргааны ажилчдаас авах асуумж /төрийн захиргааны ажилчид/
4. Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгчдөөс авах асуумж
5. Шүүхэд хандаж байсан олон нийтээс авах асуулга
6. Шүүхэд хандаж байгаагүй олон нийтээс авах асуулга
7. Эрх зүйн ангийн оюутнуудаас авах асуумж

Тандалт судалгаа нь зураг 1-д үзүүлсэнчлэн үндсэн гурван үе шатаас бүрдэнэ.

Зураг 1. Судалгааны үйл явц



Судалгааны сэдвийн хүрээнд өмнө нь хийгдэж байсан судалгаа, шинжилгээний ажил байгаа эсэхийг судлан тус судалгааны зорилго, зорилт болон судалгааны арга зүй зэргийг нарийвчлан тодорхойлж, асуумжийг боловсруулах ажлыг бэлтгэл үе шатны хугацаанд хийж гүйцэтгэлээ. Судалгааны асуумж нь шаардлагатай мэдээллийг хамгийн бага алдааны түвшинд, үр ашигтай цуглуулах боломжийг олгодог. Иймд асуумжыг боловсруулахын тулд олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмжийг судалж, түүнтэй уялдуулан боловсруулсан болно.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа компьютерт суурилсан мэдээлэл цуглуулалтын аргаар авсан болно. Гэхдээ шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгчидийн судалгааг CATI¹ буюу телефон утсыг ашиглан зайнаас мэдээллийг цуглуулсан болно.

Цугларсан өгөгдөлд дата анализ хийхэд боломжтой байдлаар хувирган, дүн шинжилгээ хийж, суурь судалгааны эцсийн тайланг боловсрууллаа.

¹ CATI энэ арга нь судалгааны программ ашиглан телефон утсаар судалгаа авах арга юм.

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР

Судалгааг 2023 оны 08 сарын 30-ны өдрөөс 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн хугацаанд нийт 1,583 хүн судалгаанд хамрагдсан байна. Үүнийг задалж харвал;

- Шүүгч-193
- Экспертүүд (өмгөөлөгч, прокурор, хуульч болон ИДС-ийн багш нар)-90
- Шүүхийн захиргааны албан хаагч-639
- Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч-177
- Шүүхээр үйлчлүүлсэн иргэд-282
- Шүүхээр үйлчлүүлж байгаагүй иргэд-167
- Эрх зүйн ангийн оюутнууд-35



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ШҮҮГЧЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН






1.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү дэд бүлэгт онлайн судалгаанд оролцогчдийн ерөнхий мэдээллийг задлан харуулав.


График 1. Судалгаанд оролцогчдын нас хувиар, судалгаанд оролцсон шүүгчийн байршил тоогоор



Судалгаанд оролцсон 193 шүүгчийн дийлэнх хувь нь 31-50 насныхан байна.

Судалгаанд хамрагдсан 193 шүүгчдийн 85 шүүгч нийслэлээс, 83 шүүгч орон нутгаас, 9 шүүгч сум дахь сум дундын шүүхээс харин 16 шүүгчийн хариулт тодорхойгүй байна.

График 2. Шүүгчээр ажилласан жил



Харин шүүгчээр ажилласан жилийг задалж харахад 66 хувь нь 7-н жил дээш жил ажиллаж байгаа бол 17 хувь нь 4-6 жил харин 1-ээс 3 жил болон 1 жил хүртэл тус бүр 8 хувь нь ажиллаж байна.

График 3. Албан тушаал






ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Судалгаанд оролцсон нийт 193 шүүгчийг 100 хувь гэж үзвэл 81 хувь нь шүүгч харин 19 хувь нь ерөнхий шүүгчээр ажиллаж байна. (Ерөнхий шүүгч болон шүүгчийг цаашид шүүгч гэнэ.)

График 4. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа дараах үйл ажиллагаатай санал нийлж буй эсэх



Шүүхийн шинэтгэлийг бүхэлд нь график 4-ийн нийт гэсэн үзүүлэлтийг харахад шүүгчдийн бүрэн санал нийлж байна, санал нийлж байна гэсэн хувилбар нийт хариултын 44 хувь нь эзэлж байгаа нь шүүхийн шинэтгэлийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжиж байгаа нь харагдсан юм.

Мөн шүүхийн шинэтгэлийн хүрээн дэх үндсэн 5 ажлыг задалж харахад шүүхийн зохион байгуулалтыг Үндсэн хуульд бүрэн нийцүүлсэн болон шүүхийн цахимжилтын ажил үр дүнтэй хэрэгжиж байна гэж үзжээ.

Харин шүүгчийн ажлын ачааллыг тооцсон жишиг шалгуурыг оновчтой тогтоох хүрээнд хийгдсэн ажил, шүүхийн захиргааны ажилчдын нийгмийн баталгааг хангах болон шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг оновчтой тогтоосон зэрэг ажлын хувьд дунджаар 33 хувь нь зарим талаараа үр дүнтэй гэсэн бол дунджаар 22 хувь нь санал нийлэхгүй, дунджаар 10 хувь нь огт үр дүнгүй гэжээ.

Мөн график 4-ийн хүрээнд дараах саналыг ирүүлсэн байна. Үүнд:

1. Зөвхөн иргэний хэргийн бүртгэлийн ажлыг программаар хийж байгаа бусдаар цахимжилт явагдаагүй. ИХШХШТХ-д өөрчлөлт оруулж, нотлох баримтаа цахимаар авч, зарим онцгой шийдвэр, захирамжаас бусдыг шууд программаас хэвлэдэг болгох шаардлагатай.

2. Шүүхийн захиргааны ажилтнуудын цалинг өнгөрсөн жил нэмснээс бусдаар нийгмийн баталгааг хангах ямар нэгэн ажил хийгээгүй.

3. Ажлын ачааллын жишиг шалгуур маш буруу болсон гэж үзэж байна. Зөвхөн шийдвэрлэсэн хэргээр тооцохгүй, хүлээн авсан хэрэг, эрдэм шинжилгээ, багшлах зэрэг ажлыг харгалзах хэрэгтэй. Эрдэм шинжилгээ, багшлах ажлыг



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

оролцуулахгүй байгаа нь шүүгчийн унших, судлах хандлагыг үгүй хийх нөхцөлийг бий болгож байна гэжээ.

Хүснэгт 1. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудтай санал нийлэхгүй байгаа шалтгаануудыг харуулав.

Санал нийлэхгүй байгаа шалтгаан	Санал хэлсэн хүний тоо
<p>Шүүхийн захиргааны ажилчдын нийгмийн баталгааг хангалттай хангаж чадахгүй байна. Тодруулбал:</p> <p>Шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилчдын цалин хөлс хангалтгүй, нийгмийн баталгаа байхгүй, шүүгчийн туслахууд байнга бусдад загнуулж, зарим тохиолдолд шүүхэд хандсан иргэдэд доромжлуулж, зодуулж гэмтэл учирсан тохиолдол гардаг. Залуу ажилчдын хувьд ажлын байран дахь орчин болон хувь хүний амьдрах /орон байр, унаа г.м/ орчин нөхцөл сайжрахгүй байгаа нь ажиллах урам зоригийг мохоох мөн гэр бүлтэй ажилчдын хувьд хүүхдийн боловсрол, чанартай хоол хүнсээр хангагдах наад захын хэрэгцээнд өрхийн санхүү нь хүрэлцэхгүйгээс ажлаас халшрах асуудал үүсэж байна. Иймд шүүхийн захиргааны ажилчид ялангуяа нийслэлд маш их илүү цагаар ажиллах нөхцөл байдал үүсдэг тул илүү цагийн хөлс, эсхүл ажлын ачаалал тооцсон үзүүлэлт урамшууллыг бий болгох шаардлагатай байна.</p>	19
<p>Шүүгчийн ажлын ачааллыг тооцсон жишиг шалгуурыг оновчтой тогтоогоогүй. Тодруулбал:</p> <p>Шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо бодит нөхцөл байдлыг харгалзаж үзээгүй. Нийслэлийн болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг ялгаатай тогтоох, эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоогоор бус шүүгчийн хүлээн авч буй бүхий л хэргийг ажлын ачаалалд оруулж авч үзэх шаардлагатай. Шүүгчийн ажлын ачааллыг тооцох шалгуурыг илүү боловсронгуй болгох шаардлагатай.</p>	33
<p>Шүүхийн цахимжилт хангалтгүй байна. Тодруулбал:</p> <p>Шүүхийн цахимжилт хангалтгүй бөгөөд нэн тэргүүнд шүүхийн захиргааны ажилчдын хэрэглээний программууд албан ёсны лицензтэй болгох. Бид ШЕЗ-д уламжлаад албан ёсны лиценз авах хүсэлт гаргахыг Тамгын газарт хэлдэг боловч огт арга хэмжээ авахгүй удаж байна. Үүнээс болоод системүүд бүрэн утгаараа ажиллаж чадахгүй, мэдээ тайлан ч гарахгүй байгаа систем заримдаа ажилтнуудын ачааллыг хөнгөлөх биш ачааллыг нэмдэг.</p>	6
<p>Шүүх эрх мэдэл болон ШЕЗ-тэй холбоотой санал</p> <ul style="list-style-type: none"> • Бодлогын түвшинд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь бодит байдал дээр хэрэгжихэд хүндрэлтэй, судалгааг сайтар хийдэггүй бөгөөд ШЕЗ-ийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаа хангалтгүй байна. • Шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын адил хэмжээнд тэнцвэржээгүй. • Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн зарим заалт нь Үндсэн хуульд нийцэхгүй байгааг анхаарах хэрэгтэй байна. • Шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад ШЕЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байна. 	7
<p>Бусад санал:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүхийн туслахын албан тушаалд хуульчийн шалгалтад тэнцсэн байх шаардлага тавьсныг эргэн харах шаардлагатай байна. • Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтнээр ажиллаж байгаа ажилтныг мэргэжлээрээ ажилласан хугацаанд тооцдоггүй, тухайн шүүхийн байгууллагад ахиж дэвшин ажиллах боломжгүй зэргээс ажиллах хүчний хомсдол үүсэж байна. 	19



- Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт хуульчийн шалгалт өгөх боломжийг бий болгох хэрэгтэй байна.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанаас бодлогын түвшинд сайн боловсруулагдаагүй гэж нэн тэргүүнд шүүгчийн ажлын ачааллыг тооцсон жишиг шалгуурыг нэрлэж байна.

Тус жишиг шалгуурыг тооцохдоо бодит нөхцөл байдлыг харгалзаж үзээгүй. Нийслэлийн болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг ялгаатай тогтоох, эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоогоор бус шүүгчийн хүлээн авч буй бүхий л хэргийг ажлын ачаалалд оруулж авч үзэх шаардлагатай. Шүүгчийн ажлын ачааллыг тооцох шалгуурыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна гэжээ.

Шүүх, иргэд, олон нийтэд шүүхийн үйлчилгээг бүрэн хүргэхийн тулд шүүхийн нөөцийг буюу шүүгч, шүүгчийн туслах, шүүхийн захиргааны бусад ажилтныг зохистой хуваарилах асуудалтай тулгардаг. Шүүхээр шийдвэрлүүлэхээр ирсэн бүх хэрэг маргааныг шийдвэрлэхэд хэдэн шүүгч, шүүгчийн туслах, шүүхийн захиргааны бусад ажилтан шаардлагатайг тооцоолсноор шүүх, шүүгчийн ажлын ачааллыг нарийвчлан хэмжих боломжтой.²

Олон улсын практикт шүүгчийн ажлын ачааллыг тооцох, үнэлэхэд дараах гурван уламжлалт аргачлалыг хэрэглэдэг байна. Тодорхой хэрэг, маргаанд зарцуулж буй минутаар ачаалал тооцох буюу “Хэргийн ачааллаар үнэлэх аргачлал” /the weighted caseload method/, Делфи /Delphi method/ аргачлал нь тухайн тойрог дахь нийт хэргийн тоог нийт шүүгчдийн тоонд хувааж гаргадаг, Норматив аргачлал /the normative method/ нь тухайн салбарын шинжээч, мэргэжилтэн /шүүгч болон хуулийн салбарын бусад мэргэжилтэн/ нарын санал дээр үндэслэн өөр өөр төрлийн хэрэг, маргаанд заруулагдах дундаж хугацааг тооцон гаргадаг. Тус гурван арга нь өөр өөрсдийн онцлогоос хамааран давуу болон сул талтай учраас АНУ-ын Холбооны болон мужийн шүүхүүд шүүх болон шүүгчийн ажлын ачааллыг тооцохдоо тухайн мужийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, өмгөөлөгчдийн тоо, шүүгчийн ажил үүргийн шаардлагаар өөр муж, газруудад явахад зарцуулсан хугацаа зэргийг харгалзан үзэж тухайн муж бүрийн онцлогт тохируулан дээрх гурван аргачлал дээр үндэслэн Hybrid буюу холимог аргачлалаар боловсруулдаг байна.

Тус холимог аргаар 2018 онд “Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгаа”-г тус аргаар боловсруулсан байна. Тус судалгааны ганцаарчилсан ярилцлагад нийт 25 эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч оролцсон бол ажлын байрны зураг авалтаар 13 шүүгч оролцсон нь аргачлал зөв боловч судалгааны түүврийн хэмжээ хангалтгүй буюу эх олонлогийг төлөөлөхүйц биш байв.


² Cf Wisconsin Director of State Courts Office, Judicial Needs Assessment 206, Final Report, p.7.



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

График 5. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг харуулав



Сүүлийн 2 жилийн хугацаанд дээрх шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөнийг үнэлүүлэхэд Монгол улсын дээд шүүхийн үйл ажиллагааг нийт шүүгчдийн 86 хувь нь сайжирсан, өөрчлөгдөөгүй гэсэн хариулт дээр санал хуваагдаж байна. Харин мэдэхгүй гэсэн хариултын хувьд хамгийн их хувийг Монгол улсын дээд шүүх эзэлж байна. Үүнээс харахад Монгол улсын дээд шүүхийн талаарх асуултад шүүгч нар болгоомжтой хандаж байгааг харуулж байна. Нөгөө талаас Монгол улсын дээд шүүхийн үйл ажиллагааны талаарх тийм их нээлттэй бус байх магадлалтай юм.


ШЕЗ-ийн хувьд дээд шүүхтэй мөн адил 76 хувийг сайжирсан болон өөрчлөгдөөгүй гэсэн хариулт тэнцүү хувийг эзэлж байна.

Харин тамгын газрын үйл ажиллагааны хувьд шүүгчдийн олонх нь буюу 48 хувь нь өөрчлөгдөөгүй хэвээрээ гэжээ.

Үнэлгээ тус бүрээр харвал сайжирсан гэсэн хувилбарын хувьд Монгол улсын дээд шүүхийн үйл ажиллагаа сайжирсан байна.


Өөрчлөгдөөгүй гэсэн хувилбарын хувьд ШТГ-ын үйл ажиллагаа өөрчлөгдөөгүй байна. Харин дордсон гэсэн үнэлгээний хувьд ШЕЗ-ийн үйл ажиллагааг нэрлэсэн байна.

График 6. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг албан тушаал тус бүрээр






Монгол улсын дээд шүүхийн үйл ажиллагаа



Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа




Сүүлийн 2 жилийн хугацаанд дээрх шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөнийг шүүгч нарын албан тушаал буюу ерөнхий шүүгч болон шүүгчээр харьцуулан харъя. Үүнд:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг нийт шүүгчдийн олонх нь буюу 39 хувь нь (n=61) сайжирсан гэсэн бол ерөнхий шүүгчдийн 46 хувь нь (n=17) өөрчлөгдөөгүй гэжээ.
- Монгол улсын дээд шүүхийн үйл ажиллагааны хувьд ерөнхий шүүгчдийн олонх нь буюу 51 хувь нь (n=19), шүүгчдийн 44 хувь нь (n=69) сайжирсан гэж үзжээ.
- Харин Тамгын газрын үйл ажиллагааг ерөнхий шүүгчдийн 51 хувь нь (n=19), шүүгчдийн 47 хувь нь (n=74) өөрчлөгдөөгүй гэж хариулсан нь хамгийн их хувийг эзэлж байна.

Дараах графикт сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэхэд шүүгчээр ажилласан жил хэрхэн нөлөөлж байгааг хувь болон хариулсан хүний тоогоор харуулав.


График 7. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг шүүгчээр ажилласан жилээр






Дараах 8-аар графикт сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэлэх асуумжид шүүгч нарын насны бүлгээр харьцуулан харуулав.

График 8. Сүүлийн 2 жилийн хугацаанд дараах шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааг хэрхэн өөрчлөгдсөн болохыг шүүгчдийн насны бүлгээр






ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН
Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв



Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны хувьд 51-ээс дээш насныхны олонх нь сайжирсан гэсэн хариултыг өгсөн байна.

Монгол улсын дээд шүүх болон шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаа сайжирсан гэсэн үнэлгээ насны бүлэгтэй шууд эерэг хамааралтай байна.

График 9. Шүүгчийн ёс зүй ба хариуцлага, хараат бус байдалтай холбоотой бодомжид санал нийлж байгаа эсэх



Шүүгчийн ёс зүй ба хариуцлага, хараат бус байдалтай холбоотой бодомжийн хүрээнд шүүгчид хэрэг, маргааныг зохих ёсоор шийдвэрлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэг маш сайн буюу энэхүү бодомжтой бүрэн санал нийлж байна.



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв


График 10. Шүүгчид сахилгын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөх талаарх заавар, зөвлөмж, аргачлал хангагдсан эсэх



Шүүгчид сахилгын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөх талаарх заавар, зөвлөмж, аргачлалыг нийт шүүгчдийн 13 хувь нь маш сайн хангагдсан гэсэн бол хангагдсан болон зарим талаараа хангагдсан гэж тус бүр 32 хувь нь, харин 22 хувь (n=43) нь хангагдаагүй гэж үзсэн байна.

Үүнээс харахад тус асуумжийн хүрээнд заавар, зөвлөмж, аргачлалыг илүү сайжруулах шаардлага байгааг харуулж байгаа бөгөөд энэхүү хүрээнд судалгаа, шинжилгээ хийх нь зүйтэй.

График 11. Шүүгчдийн ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд ямар ажлыг нэн яаралтай хийх ёстой болохыг харуулав



Шүүгчдийн ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд нэн тэргүүнд шүүгчийн цалин, урамшууллын системийг сайжруулах нөхцөл байдал үүссэн байна.

2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр бүх шатны шүүхийн шүүгчдийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоож, шүүхийн шатлалаар 2 сая 700 мянгаас 3 сая 300 мянга төгрөг болсон байна.



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН
Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Зураг 1. 2015 онд батлагдсан бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны
101 дугаар тогтоолын хавсралт

БҮХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр)
1	Хяналтын шатны шүүхийн Ерөнхий шүүгч	3 300 000
2	Хяналтын шатны шүүхийн шүүгч	3 200 000
3	Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	3 000 000
4	Давж заалдах шатны шүүхийн Шүүгч	2 900 000
5	Анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	2 800 000
6	Анхан шатны шүүхийн шүүгч	2 700 000

Үүнээс хойш 8 жилийн хугацаанд Монгол банкнаас гарсан инфляцын тоон үзүүлэлтийг харахад маш тогтворгүй байгаа нь харагдаж байна. Мөн 2021 оноос 2023 оны 07 сар хүртэлх инфляцын түвшин өндөр байна. Энэ нь хэрэглэгч нар бараа бүтээгдэхүүнд өндөр үнэ төлж байгаа нэг илэрхийлэл юм.

Гэтэл шүүгч нарын цалин 2015 онд батлагдсан хэмжээ хэвээр байна.

Зураг 2. Хэрэглээний үнийн индекс (ХҮИ)-ээр илэрхийлэгдсэн инфляц³



Жишээ нь: Шүүгч нараас хамгийн өндөр цалин авч байгаа хяналтын шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн цалинг 1 ам доллартой харьцуулбал.

2015 оны 1 сарын байдлаар $3,300,000/1,925.81\$=1,743.34\$$

2023 оны 1 сарын байдлаар $3,300,000/3,444.6\$=958.02\$$

³ <https://www.mongolbank.mn/mn/inflation>, 2023 оны 09 сарын 15-ны өдөр



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Зөрүү $1,743.34\$ - 958.02\$ = 785.32\$$ байна. Энэ нь доллартой харьцуулсан бодит орлого буурсан болохыг харуулж байна.

Зураг 3. Монголбанкнаас зарласан валютын ханш⁴



Судалгаанд оролцогчийн санал:

Шүүгчийн цалин урамшууллыг 2015 оноос хойш огт нэмээгүй 8 жил өнгөрсөн байна. Шүүгчийн цалин нь компани, төрийн байгууллага болон бусад байгууллагын хуульч, өмгөөлөгч нараас бага, ахуйн хэрэгцээний наад захын хэрэглээг хангахад хүрэлцэхгүй байдал нь хараат бус, бие даасан байдлыг хангаж чадахгүй, шүүхийн хүний нөөцийн асуудал тогтворгүй байдалд хүргэж байна. Бусад бүх байгууллагуудын ажилчид, төрийн албан хаагчдын цалин цаг үеийн нөхцөл байдал, үнийн хөөргөдлийн улмаас нэмэгдсэн байхад шүүгч нарын цалин хэвээр нэмэгдэхгүй байгааг ойлгохгүй байна. Энэ тал дээр Шүүхийн Ерөнхий зөвлөл арга хэмжээ авч ажиллахгүй байна. Шүүгч нарынхаа эрх ашгийг хамгаалахгүй байна. Ёс зүйн, сахилгын шийтгэл, хариуцлага тооцох асуудлыг өндөрт авч үзэхээс биш, шүүгч нарын эрх ашгийг хангах үүднээс ажлаа хангалтгүй хийж байна. Төрийн албаны бусад байгууллагууд ажилчдаа /20-30 мянган төрийн албан хаагч байна/ орон сууцжуулж, өмчлүүлж байхад 500 гаруйхан шүүгч нарынхаа ийм асуудлыг шийдвэрлэх чадамжгүй байна. Орон сууц, амьдрах байр наад захын хэрэгцээ шаардлага шүү дээ.

График 12. Шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдын дараах асуудлын алийг нь илүү анхаарч ажиллах ёстой вэ?

⁴ <https://www.mongolbank.mn/mn/inflation>, 2023 оны 09 сарын 15-ны өдөр



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв



Шүүгч нар шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдын хүрээнд хүний нөөцийн орон тооны асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх хэрэгтэй гэсэн байна. Удаах нь шүүхийн шинэтгэлийн тухай хуулийг дахин харах түүнчлэн удирдах түвшний болон захиргааны ажилчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна гэжээ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар шүүхийн шүүгчийн орон тоог баталсан.⁵ Энэхүү тогтоолд Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 79 дүгээр тогтоолоор шүүхийн шүүгчийн тоог 699 болгож нэмэгдүүлэв. Гэвч 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 493 шүүгч ажиллаж байгаа нь өнөөг хүртэл 206 шүүгчийн орон тоо дутуу ажиллаж байна.

Харин шүүхийн захиргааны ажилчдын орон тооны хувьд 2023 оны анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын орон тооны хязгаар 1,458 байгаагаас 2023 оны эхний хагас жилийн байдлаар 1,332 албан хаагч ажиллаж байгаа нь 126 орон тоо дутуу ажиллаж байна.⁶

Иргэдийн хууль ёсны ашиг сонирхол, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд шүүхийн үйлчилгээг хэвийн, хүртээмжтэй явуулахад шаардлагатай хүний, санхүүгийн, материаллаг нөөцийн асуудал нь шүүхийн дэд бүтэц, нөөцийн хүрээн дэх асуудал юм.

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=103470&showType=1>

⁶ ШЕЗ-ийн статистик мэдээлэл



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Мөн дараах хүснэгтээс харахад хүний нөөцийн орон тооны асуудлаа яаралтай шийдвэрлэхгүй бол одоо байгаа ачаалал жил бүр нэмэгдэх магадлалтай байна.

Хүснэгт 2. Шүүхүүдийн хянан шийдвэрлэх хэргийн тооны прогноз⁷

№	Шүүх	2022	2023	2024	2025	2026
1	ЭХАШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо	11,579	11,950	12,370	12,787	13,267
2	ЭДЗШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо	2,307	2,354	2,390	2,425	2,456
3	ИХАШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо	48,429	50,117	51,657	53,197	54,738
4	ИДЗШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо	3,319	3,445	3,576	3,705	3,835
5	ЗХАШШ-д хянан шийдвэрлэх хэргийн тоо	1,910	2,003	2,096	2,187	2,281
6	ЗХДЗШШ-д анхан шатны шүүхийн шийдвэрийг хянан шийдвэрлэх хэргийн тоо	825	872	916	960	1,004

Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн ажлын ачааллыг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөө үзүүлж байгаа хүчин зүйл бол шүүгчийн орон тооны дутмаг байдал хэмээн үзсэн байна. Шүүгчийн орон тооны хүрэлцээг шийдвэрлэх бодлогын орчин бүрдсэн ч, өнөөдөр түүний хэрэгжилт хангалтгүй байгаа нь шүүгчийн ажлын ачааллыг буруулах боломжгүйд хүргэж байгаа нь одоо ч хэвээр байгааг харуулж байна.⁸

Хүснэгт 3. Шүүгч, шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдад тулгарч буй асуудлуудыг хүснэгтээр харуулав.

Шүүгч нарын цалин бусад төрийн албан хаагчдын цалинтай адилхан болсон байна. Жишээ нь: АТГ болон бусад төрийн байгууллагын газар хэлтсийн дарга нар нэмэгдэл төрийн алба, зэрэг дэв, онцгой албаны гэх мэт нэмэгдлүүдийг авснаар үндсэн цалин 70-100 хувь нэмэгдэж байна. Мөн шүүхийн захиргааны албан хаагчид ажлын ачаалал, цалин хөлснөөс шалтгаалан ажлын байрны тогтвортой байдал алдагдаж байна.

Шүүгчийн туслахаар ажилд ороход тавигдах хуульч байх шаардлагыг эргэн харах хэрэгтэй байна.

Шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2 шүүгчийн хуралдаанд нэг нарийн бичиг ороод ажлаа гүйцэж хийхэд бэрхшээлтэй байдаг. Тэмдэглэлийг хүлээх нөхцөл байдал бий болдог

Шүүх өөрийн гэсэн байгууллагын соёлтой болсноор сайн хуульчдын шүүхийн байгууллага руу орох өрсөлдөөн нэмэгдэх болно. Үүний тулд хүний нөөцийн бодлогыг сайжруулж, албан хаагчдын мэдлэг, хувь хүний хөгжлийг дэмжсэн үр дүнтэй сургалтын хөтөлбөртэй болох хэрэгцээ байна. Жишээ нь: Хувийн хэвшлийн компаниуд ажилтнуудаа жил бүр эмнэлгийн үзлэгт хамруулах, хувь хүний хөгжлийн сургалтад хамруулах, амьдралын дасгалжуулагч (life coach), сэтгэл зүйч ажиллуулах зэргээр ажилтнуудыг сэтгэл хангалуун байх нөхцөлөөр хангадаг ба эдгээр шинэлэг арга барилаас суралцаж, нэвтрүүлэх шаардлагатай.

Гадаад улс орны экспертүүдийг авчрах зайлшгүй шаардлагатай гэж бодохгүй байна. Эрх зүйн тогтолцоо өөр улсаас эксперт ирлээ гэхэд ач холбогдол, үр дүн багатай байх болов уу. Харин эсрэгээрээ шүүх

⁷ Шүүгчийн ажлын ачаалал тооцох, хэргийн коэффициент тодорхойлох, баталгаажуулах судалгаа, хуудас-252-255, Улаанбаатар хот, 2022 он.

⁸ Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан, хуудас-69, Улаанбаатар хот, 2018 он



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

бүрээс нэг нэг төлөөлөл бүхий захиргааны ажилтнуудыг Монгол улстай адил эрх зүйн тогтолцоо бүхий улс орны шүүхийн үйл ажиллагаатай танилцах боломж олгож, өөрийн шүүхдээ сургагч багшаар ажиллуулан, шүүхийн шинэтгэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын туршлага судлуулах нь зөв гэж бодож байна.

Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сахилга, ёс зүйн зөрчил гаргасан гэх хэмжээнийхээ хүрээнд явуулах. Шүүн таслах ажиллагаа руу хэт ихээр хальж орж байгаа нь шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах итгэл үнэмшил алдагдаж, сэтгэл зүйн хувьд маш ихээр сөргөөр нөлөөлнө. Түүнчлэн энэ хальсан ажиллагаанаас шалтгаалан маргалдагч, төлөөлөгч, өмгөөлөгч нар сүрдүүлэх маягийн хандлага гаргах нь их болсон. Энд нөлөөллийн мэдүүлэг хөтлөхөөргүй маягаар хандлага илэрхийлж буй хэлбэрийг орууллаа.

Шүүхийн ерөнхий зөвлөл тамгын газрын үйл ажиллагааг сайжруулах тал дээр илүү сайн анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 4. Шүүгч нарт ямар төрлийн хэрэг маргаан хамгийн их ачаалал үүсгэдэг гэж бодож байна вэ?

Хэргийн төрөл болон асуудлууд	Санал ирүүлсэн хүний тоо
Хэргийн оролцогч, хавтасны тоо олон мөн олны анхаарлыг зориудаар татсан, хэвлэл мэдээллийн сувгаар урьдчилан мэдээлэгдсэн хэргүүд болон хууль эрх зүйн мэдлэг, өмгөөлөх эрхээр хангагдаагүй этгээдүүдийн хоорондын маргаан ачаалал их үүсгэдэг.	27
Бүхий л төрлийн хэрэг, маргаанууд жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь ачаалал үүсгэдэг, тодорхой төрлийн гэж тодорхойлох боломжгүй. Шүүхэд нэхэмжлэл гаргах буй иргэдийн тоо жилээс жилд ихсэж байгаа ч, шүүгчийн орон тоо хангалттай бус байгаатай холбоотойгоор их ачаалал үүсгэж байна. Хэрэг, нэхэмжлэл хуваарилах журам учир дутагдалтай, ачаалал ихтэй газрын шүүгч нарыг улам ачааллын нэмж байна. Иймд хүний нөөцийн бодлогыг дээд шатны удирдлагууд зөв явуулах хэрэгтэй байна.	22
Бас шүүх хуралдаан хойшлох болон сахилгын хороонд бичсэн өргөдөл бүрийг хүлээн авч хэрэг үүсгэж, шийдвэрлэж байгаа нь хэрэг шийдвэрлэх хугацаанд нөлөөлж зохиомол ачаалал үүсгэж байна.	20
Зөрчлийн хэргүүд ачаалал их үүсгэж байна.	20
Гэр бүлийн гишүүдийн хоорондох маргаан, өв залгамжлалын маргаан, гэр бүлийн хүчирхийллийн хэргүүд ачаалал үүсгэдэг.	19
Бүх төрлийн зээлийн маргаан, бага болон өндөр үнийн дүнтэй хэргүүд.	16
Төрөл бүрийн гэрээний маргаанууд, хөдөлмөрийн гэрээ, орон сууц гэрээ, хуулийн этгээд хоорондын гэрээ мөн хуулийн этгээдийг дампуурсанд тооцож татан буулгах, хуулийн этгээдийн хувьцаа, тендер зэрэг хэргүүд ажлын ачаалал үүсгэж байна.	13
Авлига болон албан тушаалтны гэмт хэрэг мөн хулгай, залилангийн хэргүүд ачаалал их үүсгэдэг.	12
Захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэж буй хэрэг маргаанууд, тэр дундаа газрын маргаан, эд хөрөнгийн болон өмчлөлийн эсрэг хэргүүд, татварын хэрэг ачаалал их үүсгэдэг.	10
Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гарсан хэргүүд ачаалал үүсгэж байна.	9
Хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг хэргүүд ачаалал үүсгэж байна.	8
Хэрэг маргааны ялгаатай байдлаас илүүтэй итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч нарын оролцооны байдлаас шалтгаалж байна. Мөн нотлох баримт дутуу байх, механик ажлууд, өмгөөлөгч, төлөөлөгчийн харилцаа, өөрсдийн ажлаа шүүхээр хийлгэх гэсэн хүсэлт, шүүх хуралдаан хойшлуулах гэсэн үндэслэлгүй хүсэлтүүд ачаалал үүсгэдэг.	8

Дээрх хүснэгтэд үзүүлсэн хэргийн төрөл болон шалтгаанууд нь нийтлэг болохыг санал ирүүлсэн хүний тооноос харагдаж байна. 2018 оны “Шүүгчийн ажлын ачаалал тооцох судалгааны тайлан”-д шүүхийн байгууллагын орон тооны хүрэлцээгүй байдлаас ажлын ачааллыг нэмэгдүүлж байгаа удаах нийтлэг хүчин



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

зүйл бол шүүх хурал хойшлох явдал болох нь тус судалгаанаас харагдсан байна⁹. Үүнтэй холбоотойгоор ШЕЗ нь “Шүүх хуралдаан хойшилсон шалтгаан, нөхцөлийг тодруулах нь” гэсэн хүрээнд нарийвчилсан судалгааг 2023 оны 08 дугаар сард хийж гүйцэтгэсэн болно.

График 13. Шүүхийн захиргааны ажилчдын ажлаас гарч байгаа шалтгаан (n=196 давхардсан утга=686)



Шүүхийн захиргааны ажилчдын ажлын ачаалал их, ажилчдын нийгмийн асуудлыг оновчтой тодорхойлсон бодлого байхгүй, цалин хангамж бага зэрэг асуудлаас болж ажлаас гарч байна гэж шүүгч нар үзэж байна.

ШҮҮХИЙН ДЭД БҮТЭЦ, НӨӨЦ, ҮР АШИГТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БОЛОН ШЕЗ-ТЭЙ ХОЛБООТОЙ ХЭСЭГ

График 14. Дараах шүүхийн байгууллагатай холбогдох бодомжуудтай санал нийлэх үү?



⁹ Шүүгчийн ажлын ачаалал тодорхойлох судалгааны тайлан, хуудас-69, Улаанбаатар хот, 2018 он



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Шүүхэд ирэх хэрэг, маргааны тоонд гэнэтийн, огцом өөрчлөлт бий болбол шүүх түүнийг даван туулах хангалттай нөөц, бололцоогоор хангагдсан гэсэн бодомжтой шүүгч нар санал нийлэхгүй байгаа шалтгаан нь хүний нөөцийн орон тооны асуудал, шүүхийн менежмент мөн цахимжилт зэрэг асуудал шууд хамааралтай юм. Тус асуудлууд сайжирснаар шүүхийн үйл ажиллагаа тогтвортой, ажилчдын ачаалал хэвийн болох боломжтой юм.

График 15. Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбогдох бодомжуудтай санал нийлэх үү?



Шүүх бие даасан байх, шүүгч бусдаас хараат бусаар, хөндлөнгийн аливаа зүй бус нөлөөллөөс ангид ажиллах ёстой. Үүний тулд шүүх, шүүгчийн аюулгүй байдлын баталгааг ШЕЗ хангаж ажиллах чиг үүрэгтэй юм.

Тус чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа гэсэн бодомжид шүүгч нарын 22 хувь нь санал нийлэхгүй, 11 хувь нь огт санал нийлэхгүй гэж хариулсан байна.

Харин ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг гэсэн бодомжтой судалгаанд оролцсон нийт шүүгчдийн 11 хувь нь санал нийлэхгүй, 6 хувь нь огт санал нийлэхгүй гэсэн бол 15 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн байна.


График 16. Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбогдох бодомжуудтай санал нийлэх үү? Ажилласан жилээр харьцуулан харвал.



ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг гэсэн бодомжийг шүүгч нарын ажилласан жилээр харьцуулан харахад 4-6 жил ажилласан шүүгч нар олонх нь бүрэн болон санал нийлж байна гэсэн хариултыг өгсөн байна.



График 17. Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөлтэй холбогдох бодомжуудтай санал нийлэх үү? Ажилласан жилээр харьцуулан харвал.




ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг гэсэн бодомжийг шүүхэд ажилласан жилээр харьцуулан харахад мөн адил 4-6 жил ажилласан шүүгч нар санал нийлж байгаа болон бүрэн санал нийлж байна гэсэн хувилбарыг хамгийн их сонгосон байна.

График 18, 19-д ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг болон ШЕЗ ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг гэсэн бодомжуудыг шүүгчийн албан тушаалаар харьцуулан харуулсан болно.

График 18. ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг



График 19. ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг гэсэн сонголтыг албан тушаалаар харьцуулан харвал.





ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

График 20. Таны хувьд ямар хэлбэрээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргэж буюу албаны мэдээллүүдийг илүү хурдан шуурхай, оновчтой байдлаар Танд хүрэх вэ?




Шүүгч нар албан мэдээллийг албан мэйл хаягаар авах нь илүү хурдан шуурхай, оновчтой байх болно гэж хариулсан байна. Мөн хамгийн их хувийг эзэлж байгаа дараагийн хариулт бол гар утасны аппликейшнтай болох гэсэн хувилбар байсан тул энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийх.

Түүнчлэн шүүгч нар дараах шүүмжүүдийг ирүүлсэн байна. Үүнд:

- Judscouncil.mn хаягаа ядаж хангалттай сайн ажиллуулах хэрэгтэй. Одоо байгаа хаягаар орохоор ихэнх тохиолдолд гацах, хоцрогдсон мэдээлэл байдаг.
- Албаны мэйл хаягаар мэдээллээ хүргүүлэхийн зэрэгцээ шүүхүүд дотооддоо ашиглах интернэттэй болвол ажил илүү үр дүнтэй, бүтээмжтэй, хурдан шуурхай байх болно.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн сайт дээр мэдээллийг нээлттэй хурдан шуурхай, цаг алдалгүй байршуулах хэрэгтэй.

ШҮҮХЭД ИТГЭХ ОЛОН НИЙТИЙН ИТГЭЛ, ШҮҮХИЙН НЭЭЛТТЭЙ ИЛ ТОД БАЙДАЛ

График 21. Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна бэ? Насны бүлгээр харьцуулан харуулав.



Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн болохыг харахад хамгийн их хувийг дордсон гэсэн хариулт эзэлж байна. Харин насны бүлгээр харьцуулан хамгийн их хувийг эзэлж байгаа хувилбарыг харахад 41-50 насныхан дордсон гэж дүгнэсэн байна.

Харин график 22-оос харахад 7-оос дээш жил ажилласан шүүгч нарын үнэлгээнээс бусад буюу 1 жил хүртэл ажилласнаас 6 жил хүртэл ажилласан шүүгч нарын дордсон гэсэн үнэлгээ хамгийн их хувийг эзэлж байна.



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

График 22. Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна бэ? Ажилласан жилээр харьцуулан харуулав.





График 23. Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэрхэн өөрчлөгдсөн гэж бодож байна бэ? Албан тушаалаар харьцуулан харуулав.



Албан тушаалаар харьцуулан харахад ерөнхий шүүгчдийн олонх нь өөрчлөгдөөгүй гэжээ.

Харин шүүгч нарийн олонх нь сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэл дордсон гэж хариулсан байна.

График 24. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?



Шүүхийн талаарх мэдээллийг фейсбүүк, телевиз болон шүүхийн байгууллагын албан ёсны сайтаар мэдээллийг түгээх нь бусад хувилбаруудаас илүү оновчтой, хүртээмжтэй мэдээллийн суваг гэжээ.



Мөн эрх зүйн боловсрол бүхий сэтгүүл зүй */сэтгүүлчид/-*тэй хамтран ажиллаж олны анхаарал татсан хэргийн болон онцлох хэрэг маргааны талаарх бодит мэдээллийг */нууцлал алдагдуулахгүйгээр агуулгын хүрээнд/* эрх зүйн зохицуулалтын агуулгын хамтаар олон нийтэд хүргүүлэх хэрэгтэй юм.

График 25. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?



Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд ямар хэлбэрээр түгээх нь илүү оновчтой, үр дүнтэй, хүртээмжтэй аргын хувьд хандалт өндөртэй социал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх, шүүхийн байгууллагын албан ёсны сайтыг идэвхтэй байлгах болон хууль эрх зүйн анализ нэвтрүүлгийг тогтмол хийх нь хамгийн үр дүнтэй аргуудын нэг гэжээ.

Мөн тус асуултын хүрээнд дараах саналуудыг ирүүлсэн байна. Үүнд:

- Бодит байдалд нийцэхгүй худал мэдээлэлд цаг алдалгүй тайлбар няцаалтыг мөн сайт мэдээллийн хэрэгслээр нь өгөх буюу мэдээллийг тэнцвэртэйгээр хүргэх хандлагыг олон нийтийн дунд бий болгох хэрэгтэй байна.
- Олон нийтэд мэдээлэл өгдөг ажилтнуудыг эрх зүйн боловсролтой болгох сэтгүүл зүйн боловсролтой болгох. Юу гэж хэлэхээ мэдэхгүй ямар үйл ажиллагааг яаж тайлбарлахаа мэдэхгүй ажилтнууд олон нийтийн сувгаар мэдээлэл цацаж байгаа нь шүүхэд итгэх иргэдийн итгэлд сөргөөр нөлөөлж байна.
- Нийтийн зам, иргэд ихээр цуглардаг талбайд мэдээлэл хүргэдэг томоохон самбаруудтай болгосноор нийтлэг хэрэглэгддэг болон иргэд мэдвэл зохих хуулийн тодорхой зохицуулалтуудыг тодорхой, тогтмол хугацаанд өөрчлөн олны анхаарлыг татаахаар */цөөн үгтэйгээр/* мэдээллийг түгээдэг болох хэрэгтэй.
- Шүүхийн "мэдээлэл лавлагааны мэргэжилтэн" гэх ажлын чиг үүргийг тодорхой болгох. Учир нь "мэдээлэл, лавлагааны мэргэжилтэн" нэршлийн хувьд иргэдэд лавлагаа, мэдээлэл өгөх үүрэгтэй. Гэтэл одоогийн байдлаар зөвхөн нэхэмжлэл, хүсэлт, гомдол хүлээн авч, шүүгчид хүлээлгэн өгөх



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

ажил хийдэг. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд шүүх бүрт олон нийтэд мэдээлэл өгөх ажилтан ажиллуулах хэрэгтэй байна. Тус ажилчдыг тусгайлан бэлтгэх шаардлагатай гэжээ.

- Шүүхийн иргэдийн төлөөлөгчдөөр дамжуулж шүүхийг иргэдэд сурталчлах боломжтой, иргэдийн төлөөлөгчийн сургалтын чанарт анхаарч, шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчдийн бодит оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн оновчтой ажил хийх хэрэгтэй байна.
- Шүүхийн шийдвэрийн тоймыг олон нийтэд хүргэхдээ тоон дүн мэдээллээс гадна тухайн хэрэг маргааныг хэдий хугацаанд шийдвэрлэсэн талаарх анализыг агуулга хэлбэрээр мэдээлэл бэлтгэж нийтэд хүргэх шаардлагатай.
- ШЕЗ олны анхаарал татсан болон шүүгчийн нэр төрд халдсан хэрэг маргааны талаар мэдээлэл өгч байх шаардлага үүсээд байна.

Хүснэгт 5. Иргэд ямар мэдээлэлтэй байвал Танай байгууллагын үйл ажиллагаа илүү хурдан шуурхай, ойлгомжтой болно гэж бодож байна вэ?

Шүүхийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой санал	Санал хэлсэн хүний тоо
Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд иргэдийн эрх зүйн боловсрол маш чухал нөлөөтэй юм. Иргэд ХХША-ны явцад эдлэх эрх, хүлээх үүргээ мэддэг байх, шүүх хуралдааны дэгийн талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Иргэдийн боловсрол сайжирвал шүүхийн гэлтгүй аливаа мэдээллийг олж авч, анализ хийх чадвартай болно. Нотлох баримтыг өөрөө бүрдүүлэх үүргийнхээ хүрээнд шаардлагатай нотлох баримтуудаа бүрдүүлэх, өөрөө боломжгүй бол шүүхэд хүсэлт гаргаж бүрдүүлэх, хариуцагч хуулийн хугацаанд тайлбар ирүүлээгүй бол зөвшөөрсөнд тооцдог талаар мэдээлэлтэй байх зэрэг хэрэгцээ шаардлага бий тул иргэн бүрд шүүхийн үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийг өдөр тутамд мэдээллийн хэрэгслээр таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай.	22
Иргэдийн сонирхож байгаа мэдээллийг үнэн зөв, хуулийн агуулгатай, хуульд заасан ойлгомжтой байдлаар тайлбарлах.	19
Иргэд мэдээллийг ямар нэгэн эх сурвалжгүй газраас бус харин шүүхийн албан ёсны сайтаас үнэн зөв мэдээллийг авдаг болж хэвших хэрэгтэй. Мөн олон нийтийн сонирхол татаж байгаа хэрэг маргааны шийдвэрлэсэн шийдвэрийн үндэслэлийг тоймлон хүргэж байх. Шүүхээс гарах мэдээлэл бусад мэдээллээс хоцорч гарч байгаа нь иргэдэд шүүхэд итгэх итгэлийг бууруулж байна.	24
Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх, шүүгчийн талаар буруу ташаа мэдээлж буй улс төрийн өндөр албан тушаалтан, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдэд тухай бүрт дорвитой няцаалт хийж энэ талаар тодорхой арга хэмжээ авдаг, мэдээлэлдэг байх хэрэгтэй. Өнөөдөр хэн дуртай улс төрч, сэтгүүлч нь шүүхийн нэр хүндэд үндэслэлгүй халдаж байхад түүнийг няцаах чадамжгүй, хүртээмжтэй мэдээлэл гаргахгүй байна.	4
Иргэд мэдээллээр хангагдаагүйгээс шалтгаалж шүүхийн ажиллагаа удааширдаг гэж бодохгүй байгаа тул асуултад хариулах боломжгүй байна. Шүүх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд нийцүүлж явуулж байгаа. Тухайлбал, хуульд заасны дагуу хэргийн оролцогчид шүүхэд дуудан ирүүлэх, шүүх хуралдааны тов мэдэгдэх гэх мэт. Иргэдээс шалтгаалах зүйл байхгүй.	3
Иргэдэд мэдээлэл хүргэх дараах арга хэлбэрүүд байж болно. Үүнд: контент, цахим сувгууд, зурган, дүрсэн, товч бичиглэлтэй хэлбэрээр хүргэх нь илүү үр дүнтэй. Шүүхээс үйлчлүүлж байгаагүй иргэд рүү чиглэсэн ажил буюу сургалт сурталчилгааг зохион байгуулах шаардлагатай байна.	6

Хүснэгт 6. Таны хувьд нийт шүүгчдийн чуулганаар та ямар асуудлыг хэлэлцүүлээсэй гэж бодож байна вэ?




ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Нийт чуулганаар хэлэлцэх ёстой асуудлын талаарх санал	Санал хэлсэн хүний тоо
Шүүгчийн цалин хөлс, урамшууллын талаар хуульд өөрчлөлт оруулах, төрийн албаны бусад нэмэгдлүүдийг олгодог болгох мөн шүүгчийн нийгмийн баталгаа, шүүхийн захиргааны ажилчдын нийгмийн баталгаа хангах, шүүгчид зэрэг дэвийн нэмэгдэл олгох. Орон нутагт томилогдон ажиллаж байгаа шүүгч нарын эрүүл аюулгүй орчинд амьдрах боломж нөхцөлөөр хангахуйц зай талбайтай, эрүүл, цэвэр орон сууцны асуудлаар хэлэлцэх нь зөв.	46
ШЕЗ-ийн гишүүдийн анх дэвшүүлсэн зорилт, мөрийн хөтөлбөрөөс хэрэгжсэн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар хэлэлцэх. Мөн ШСХ-ны үйл ажиллагаа, жилийн тайланг хэлэлцэх. Түүнчлэн ШТХ-д Сахилгын зөрчил гэж заасан заалтуудыг мэргэжлийн хариуцлага, сахилгын хариуцлагаар нь ялгаж салгах талаарх хуулийн өөрчлөлтийг хэлэлцэж, шүүхийн сахилгын хороо түүнд итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байна.	34
Шүүгчийн ачаалал, хэрэг хуваарилалтыг зөв тогтоох, хэргийн ачаалал тооцох журмыг сайжруулах. Шүүхийн ажиллагааны нэгдсэн системийг боловсронгуй болгох асуудлыг яаралтай хэлэлцэх.	11
Хамгийн тулгамдаж байгаа асуудал нь шүүхийн нэр хүнд, шүүгчийн аюулгүй ажиллагааны талаар, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч, анхаарал татсан тодорхой хэрэг маргааныг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг мэргэжлийн тайлбартайгаар олон нийтэд мэдээлэх. ШЕЗ шүүгч гишүүдийн үйл ажиллагааг дүгнэж ШТХ-ийн 20.2.1 заасан асуудлыг хөндөх, шүүх, шүүгчийн хараат бус байдалд халдаж буй зарим улс төрчдийн болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр халдаж буй талаар хэлэлцүүлээсэй гэж бодож байна.	17
Шүүхийн боловсон хүчний тогтвортой байдлыг хэрхэн хангах, авах арга хэмжээний талаар. Шүүхийн хүний нөөц, шүүгчийг шилжүүлэн томилох асуудлын талаар хэлэлцэх ёстой.	17
ШТХ-д шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулсан зарим нэг заалтыг өөрчлөх, тус хуулийн хэрэгжилтийн асуудал болон шүүх байгуулах тухай хуулийг шүүгчдийн саналыг үл харгалзан, шүүхийн байрны боломжгүй байхад тойргийн журмаар байгуулахаар хуулийн төсөл гаргасныг дахин хэлэлцүүлээсэй гэж бодож байна.	13

График 26. Та аль шатны шүүхэд ажилладаг вэ?



Судалгаанд хамрагдсан шүүгчдийн 163 нь анхан шатны шүүхэд ажиллаж байгаа бол 30 нь шүүгч давж заалдах шатны шүүхэд ажиллаж байна.



ШҮҮГЧДЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

График 27. Та дараах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс аль төрөл дээр ажилладаг вэ?



Судалгаанд оролцсон 193 шүүгчийн олонх нь буюу 36 хувь нь тус бүр иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн шүүхэд ажиллаж байна.



ХОЁРДУГААР БҮЛЭГ

**ПРОКУРОР, ӨМГӨӨЛӨГЧ, ХУУЛЬЧ БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН
СУРГУУЛИЙН БАГШ НАРААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР
ДҮН**






ПРОКУРОР, ӨМГӨӨЛӨГЧ, ХУУЛЬЧ БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН БАГШ НАРААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нараас авсан судалгааны үр дүнг энэхүү бүлэгт танилцуулах болно.


Энэ бүлгийн асуумжид нийт 85 хүн хамрагдсан бөгөөд ажлын байдлаар нь задлан дараах графикт харуулав.

График 28 . Ажлын байдал:



Энэхүү судалгаанд прокурор болон өмгөөлөгч нар идэвхтэй оролцсон байна. Тодруулбал, 30 прокурор, 36 өмгөөлөгч, 10 хууль зүйн сургуулийн багш болон 9 хуульч оролцсон байна.

График 29. Таны бодлоор шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл хэр үр дүнтэй явагдаж байна гэж бодож байна вэ?



Энэ бүлгийн оролцогч нар шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэлийг үр дүнгүй гэж дүгнэсэн байна.

График 30. Хэрэв та үр дүнгүй болон огт үр дүн гараагүй гэсэн хариултыг сонгосон бол өөрийн харилтын шалтгааныг бичнэ үү.



Прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нар шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэлийг үр дүнгүй гэж үнэлсэн шалтгаан нь 1-рт шинээр томилогдон ажиллаж байгаа шүүгчдийн мэдлэг, ажлын ур чадвар муу, 2-рт хүний нөөцийн орон тооны асуудлаас үүссэн ажлын ачааллаа шийдэж чаддаггүй, 3-рт хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, 4-рт шүүхийн байгууллага олон нийтэд хаалттай хэвээр байсаар байна гэжээ.

Өмгөөлөгч нарын шүүхийн шинэтгэлтэй холбоотой шүүмж

- Шүүх ачаалал их байгаагаас шалтгаалж хэрэг хянан шийдвэрлэх хугацаа маш урт байна. Хуулийн хугацаанд буюу 60 хоногт багтаж хурал хийдэг хэрэг маш цөөн байдаг. Жишээ нь: Шүүх хурал дор хаяж 4 сарын дараа нэг хуралдаж, хойшлогоод 3 сарын дараа зэргээр маш удаашралтай явагдаж байгаа олон хэрэг байна.
- Мөн шүүхийн захиргаа болон архивын ажиллах журамд нэгдсэн тогтолцоо байдаггүй.
- Шүүх нь иргэдээс бүрэн тусгаарлагдсан. Давж заалдах шатны шүүхээс хэргийг буцаах боломж байхгүй болсон (*зарчмын хувьд зөв ч цагаа олоогүй, цагдаагийн байгууллагын ачаалал хэт их байгаа учраас бодитоор хэрэгжих боломжгүй байна.*)
- ШЕЗ болон шүүхийн байгууллагууд улс төрөөс ангид түүнээс хамааралгүйгээр үйл ажиллагаа явуулдаг болсон цагт шүүх эрх мэдлийн өөрчлөлт үр дүнтэй болно. Тодруулбал ШЕЗ хуульд заасан эрх үүргээ хуулийн дагуу хэрэгжүүлдэг болох хэрэгтэй, тэр цагт шүүх эрх мэдлийн өөрчлөлтийн үр дүн бусдад мэдэгдэхүйц болно. УИХ-аар батлуулсан төсвөө ч төвлөрүүлж чадахгүй, мэдэхгүй байж яаж шүүх эрх мэдлийн байгууллагыг өөрчилж чадах юм.
- Монгол улсын Үндсэн хуулиар хангагдсан хүний эрх бүрэн хангагдах эрх зүйн зохицуулалт бүрдэхгүй байна. Хуулийг шүүх бүр дур дураараа хэрэглэж байна. Прокурор, шүүгчдийн мэдлэг хангалтгүй, хуульчдаас шүүгчээр шилж сонгох ажил туйлын хангалтгүй байгаа нь хүмүүсийг хэлмэгдүүлэх байдлыг бий болгож байна.
- Шинэ шүүгчид хууль хэрэглээний тал дээр дутагдалтайгаас буруу шийдвэр их гаргаж байна. Шүүгчийн туслах утсаар холбогдож нэхэмжлэл гаргахаа больсон. Үүнээс болоод заримдаа шүүгчийн туслахыг холбогдоод өгөөч гэхээр миний ажил үүрэгт ороогүй гэдэг. Шуудангаар явуулаад хаяг дээрээ байхгүй гэх шалтгаанаар маш их буцдаг. 3 удаа буцаад эрэн сурвалжлуулж олоход анхны хаяг дээрээ лавлагаа гаргаж өгч өгсөн байдаг.
- Шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байна.
- Шүүхийн шинэтгэл үр дүн бага байгаа нь боловсон хүчний шинэчлэлтэй холбоотой санагддаг, зоригтой, хуулийг сонгодог утгаар нь сайн тайлбарлаад шийдэж чадахгүй байна. Жишээ нь: Олны анхааралд өртсөн хэрэг дээр шуурхай арга хэмжээ авах ёстой.
- Ижил үйл баримтад өөр өөр шийдвэр гаргадаг нь хэвээрээ. Ихэнх тохиолдолд ердийн хэдэн хэрэг дээр бол жигд хэрэглэдэг. Мөн манай шүүгч нар soft skill муутай санагддаг. Учир нь хүн сонсоно гэж байхгүй, хэргийн оролцогчдоос хараат бус,



хөндлөнгийн байдлаар асуулт асуухдаа дулимаг. Ёс суртахуун, хандлага ч дутагдалтай санагддаг.

- Шүүгч нар хэт олон нийтээс тусгаарлагдах нь буруу хандлага юм.

Прокуроруудаас ирсэн шүүхийн шинэтгэлтэй холбоотой шүүмж

- Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх хугацаа маш удаан байна.
- Шүүхийн байгууллагууд ашиг сонирхлын зөрчилтэй. Үүнээс болоод тодорхой хэмжээгээр хараат байх нөхцөл байдал үүсэж байна.


Хууль зүйн сургуулийн багш нараас ирсэн шүүхийн шинэтгэлтэй холбоотой шүүмж

- Шүүхийн байгууллагад мэргэшсэн хүний нөөц бага байгаа нь ачаалал үүсгэн ажилчдад үүнээс үүссэн стресс бий болж байна.
- Шүүхийн байгууллага үйл ажиллагаандаа маш олон цахим платформууд ашиглаж байгаа нь мэдээллийг хурдан шуурхай, оновчтой байдлаар хүргэх, солилцох боломжийг хааж, цахим шилжилтийг үр дүнгүй болгоход хүрсэн гэж харж байна. Үүний улмаас цахим гарын үсгийн хэрэглээ, цахим нотлох баримтын хэрэглээ нэг мөр нэвтрээгүй, шүүгчид нийтлэг байдлаар цахим нотлох баримтын талаар нэгдсэн нэг ойлголт байхгүй нь хэрэглээг хязгаарлаж байна.
- Хууль бус үйлдлээр болон хэн нэгэн эрх мэдэлтний хүчээр томилогдсон шүүгч шударга ажиллах баталгаагүй, томилгооны хүндээ үйлчилсээр л байх болно.

Хуульч нараас ирсэн шүүхийн шинэтгэлтэй холбоотой шүүмж

- ШЕЗ-ийн үйл ажиллагаа болон шүүгч нарын хэрэг хянан шийдвэрлэх ажиллаа хуулийн хүрээнд бус хувь хүний өнцгөөс харж шийдвэрүүдийг гаргаж байна.
- Шүүх эрх мэдэл намын халаасанд байна.
- Хуулиа үндсээр нь өөрчлөх шаардлагатай.

График 31. Та манай шүүгчдийн ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвар, харилцааны ур чадвар, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг хэрхэн үнэлэх вэ?



Ажлын гүйцэтгэлийг сайн гэж үзэж байгаа бол харилцааны ур чадварын хувьд анхаарах ёстойг график 31, 32 харуулж байна.

График 32. Хэрэв та дээрх асуултад муу, маш муу гэж хариулсан шалтгаанаа бичнэ үү.



Өмгөөлөгч нартай холбоотой шүүмж

Шигтгээ:

Зүгээр энгийнээр сүүлийн 5 хэрэгт орсноос 4 шүүгч нь хэргийн оролцогч нартай ялгавартай харьцдаг, өмгөөлөгч нарт хүндэтгэлтэй ханддаггүй юм аа гэхэд дундаж иргэнтэй харьцаж байгаа мэт ядаж харьцах хэрэгтэй. Дээр нь нэг тийм хөндлөнгийн байж чаддаггүй, шүүгчийн асууж буй асуулт, тогтоосон дэг, биеийн хэлэмж нь хүртэл ялгасан, үл ойшоосон харагддаг. Хууль зүйн салбарын ноён оргил ажлыг хийж байж ажилдаа дургүй, аргацаасан, маш их стресстэй, муухай ааштай, аз жаргалгүй харагддаг. Ийм байдлыг үүсгэж байгаа шалтгаанууд нь өмгөөлөгч нараас, төсөв мөнгө, ачаалал гэх мэт олон шалтгаан байгаа.

Судалгаанд оролцогчийн санал бодол

Шинээр томилогдож байгаа шүүгч нар ур чадвар муутай. Давж заалдах шатны шүүхийн шүүгч нар үг хэлүүлдэггүй, үргэлж хязгаарладаг. Зурагтаар шууд дамжуулахаар харин хязгаарлахгүй олон нийтэд таалагдах өнгө аястай.

Судалгаанд оролцогчийн санал бодол

Дээд шүүхийн шүүгч нарын харилцаа хандлага маш муу. Шүүгч нар хууль хэрэглээний хувьд хэвшмэл ойлголтоос огт салж чадахгүй байгаа. Мөн анхан шатны шүүгчдийн ачаалал хэт их.

Судалгаанд оролцогчийн санал бодол

Шинээр томилогдож байгаа шүүгч нарын ажлын ур чадвар сул байгаа нь ШЕЗ шүүгчийн ажил мэргэжилд яг таарч тохирох хуульчийг сонгон шалгаруулж чадахгүй байгаатай холбоотой. Цаашид энэ хэвээрээ байвал мэдлэг чадваргүй, хуульчдын дунд хүлээн зөвшөөрөгдөөгүй, ашиг сонирхлын зөрчилд орох шүүгчдийн тоо ихсэх болно. Мөн шүүгчийн туслахуудыг шүүгч болгодог системээ өөрчлөхгүй бол явж ирсэн муу жишиг, шүүгч нараасаа сурсан муу арга өөрчлөгдөхгүй гэж судалгаанд оролцогч нар санал бодлоо илэрхийлсэн байна.

Прокуроруудаас ирсэн шүүмж

Хэт нэг талын дүгнэлтийг буюу яллагдагч, шүүгдэгчийн үгэнд хэт автаж шийдвэр гаргадаг, хэргээ бүрэн уншиж дүгнэлт хийдэггүй, нотлох баримт харьцуулан дүгнэлт хийх чадварт суралцаагүй. Залуу шүүгчид нэмэгдэж байгаа өнөө цагт дээрх нөхцөл байдал их ажиглагддаг. Харин 40-өөс дээш насны шүүгч нарын хувьд харьцангуй гайгүй гэхдээ сул шүүгч нар байдаг.



Анхан шатны шүүхийн зарим шүүгчид хууль хэрэглээ тал дээр сул, гаргасан шүүхийн шийдвэрээ үндэслэлтэй тайлбарлаж чаддаггүй, хэт модон, өөрсдийн харж буй өнцгөөр хуулийг тайлбарладаг. Мөн хуулиас давсан журам заавар дагаж мөрдөх талаар тулган шаардах тохиолдол гарч байна.

Хууль зүйн сургуулийн багш нараас ирсэн шүүгчдийн ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвар, харилцааны ур чадвар, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой шүүмж

Хууль хэрэглээнээс гадна диспозитив зарчмаа барьж хэргийн оролцогч зохигчийг хүндэлж үлгэр жишээ хурлыг удирдах хэрэгтэй. Хэргийн оролцогчтой хэрэлдээд доошоо ороод байх шаардлагагүй хувь хүнийхээ хувьд хэрэг удирдахдаа зангаргатай бодитой хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчдийг насаар, хүйсээр ялгаварлах үйлдэл нийтлэг гаргадаг нь хүний эрхийн мэдрэмжгүй байдлын илрэл юм. Мөн эрх зүйн мэдлэггүй хэргийн оролцогчдыг загнах, шалтгаангүй уурлах зэрэг шүүгч, шүүгчийн туслах аль аль нь гаргадаг.

Хуульч нараас ирсэн шүүгчдийн ажлын гүйцэтгэл болон мэргэжлийн ур чадвар, харилцааны ур чадвар, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой шүүмж

Хууль хэрэглэх чадвар муу, шүүхийн шийдвэр хуульд заасан хугацаанд гардаггүй.

Ёс зүйн хэм хэмжээгээр баримталдаггүй, авлигад автах асуудал үүсэж байна. Мөн шүүгчдийн бусадтай харилцах харилцааны ёс зүйгүй, хүн чанараа гээгдсэн хувийн амбиц нь хэт давамгайлж байна.

График 33. Та дараах шүүгчтэй холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?



Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв

Шүүгчдийн цалин хөлс нь бусад орлогын эх үүсвэр /багшлах болон судалгааны ажил/ ашиглахгүйгээр ажиллаж, амьдрахад нь хүрэлцээтэй, тогтвортой ажиллахад хангалттай байдаг.



Шүүгчийг зөвхөн мэдлэг, ур чадвар, ёс зүйд нь үндэслэн томилдог.



Шаардлагатай үед шүүгч болон түүний гэр бүлийн гишүүдийн хувийн аюулгүй байдлыг хангадаг.



Шүүгчид хэрэг, маргааныг зохих ёсоор шийдвэрлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэгтэй байдаг.



Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй механизм, нөөц бололцоо бүрдсэн.



Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх хараат бус, нээлттэй тогтолцоо бүрдсэн.



Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа хараат бус, шударгаар явагддаг.



- Бүрэн санал нийлнэ
- Санал нийлнэ
- Зарим талаараа санал нийлнэ
- Санал нийлэхгүй
- Огт санал нийлэхгүй байна
- Мэдэхгүй


Энэ бүлгийн судалгаанд оролцогч нар шүүгчдийн цалин хөлс нь бусад орлогын эх үүсвэр ашиглахгүйгээр ажиллаж, амьдрахад нь хүрэлцээтэй, тогтвортой ажиллахад хангалттай байдаг, шүүгчийн зөвхөн мэдлэг, ур чадвар, ёс зүйд нь үндэслэн томилдог мөн шүүгчид хэрэг, маргааныг зохих ёсоор шийдвэрлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэгтэй байдаг гэсэн бодомжуудтай бусад бодомжоос илүү их санал нийлж байна.

График 34. Таны бодлоор шүүгчдийн ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд аль бодомж дээр илүү анхаарч ажиллах ёстой вэ?


Хүний нөөцийн орон тооны асуудлыг шийдвэрлэх




Захиргааны ажилчдын харилцааны ур чадварыг сайжруулах



Захиргааны ажилчдын мэдлэг, ажлын ур чадварыг сайжруулах




Шүүгч нарын ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч сургалт зохион байгуулах



Удирдах түвшний ажилчдын харилцааны ур чадварыг сайжруулах



Шүүхийн шинэтгэлийн тухай хуулийг дахин харах




Удирдах түвшний ажилчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах



Шүүгчийн цалин, урамшууллын системийг сайжруулах



Гадаад улс орны экспертүүдийг авчрах




- Нэн яаралтай
- Яаралтай
- Хойшлуулж болно
- Хийх шаардлагагүй
- Хэлж мэдэхгүй байна




Хүний нөөцийн орон тооны асуудлыг шийдвэрлэх, захиргааны ажилчдын харилцааны ур чадвар болон мэдлэг, ажлын ур чадварыг сайжруулснаар шүүгчдийн ажлын гүйцэтгэл сайжрах болно гэж энэ бүлгийн судалгаанд оролцогч нар үзсэн байна.

График 35. Та манай улсын шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг эсэхийг үнэлнэ үү.



Шүүгчийн ёс зүй ба хариуцлагын хэмжигдэхүүнийг шүүгчид хэрэг, маргааныг хуулийн дагуу, шударгаар шийдвэрлэдэг эсэхийг шүүхийн шатлалаар харьцуулав. Тус харьцуулалтаар Монгол Улсын дээд шүүхийн шүүгчдийн дийлэнх хувь нь шударгаар ажилладаг гэсэн бол анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид зарим тохиолдолд шударга гэсэн хувилбар хамгийн их хувийг эзэлж байна.

График 36. Та дараах шүүхийн байгууллагатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?



Шүүхийн дэд бүтэц, нөөцийн хувьд стандарт хангасан шүүхийн өрөө, тасалгаа шаардлагатай байгааг харуулж байна.

Нээлттэй нийгэм форумын Монгол Улсын шүүхийн индекс 2021 оны судалгааны үр дүнгээр шүүхийн дэд бүтэц, нөөцийн гэсэн үндсэн хэмжигдэхүүнд хамаарах дэд хэмжигдэхүүнүүдээс шүүхийн барилга байгууламж хамгийн бага буюу 32.34 оноог авсан¹⁰ нь нийт хэмжигдэхүүний оноог бууруулсан байна.

¹⁰ Монгол Улсын шүүхийн индекс 2021 он, ННФ, Улаанбаатар хот, Хуудас-52, 2021 он.



Удаах анхаарал хандуулах ёстой ажил бол шүүхэд хэрэгцээт мэдээллийн тоног, төхөөрөмжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

График 37.Та дараах Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-тэй холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?



ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ хангалттай хэрэгжүүлдэг гэсэн бодомжийн хувьд санал нийлэхгүй хариулт хамгийн их хувийг эзэлж байна.

Харин ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улстөрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар ажилладаг гэсэн бодомжийн хүрээнд дийлэнх хувийг зарим талаараа санал нийлж байна гэсэн хариулт эзэлж байна.


График 38.Та дараах Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?



Шүүхийн шийдвэрийн биелэлт сайн гэсэн бодомжтой (ШШГЕГ) зарим талаараа санал нийлнэ гэсэн хариулт нийт хувилбаруудын дийлэнх хувийг эзэлж байна.



График 39. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?



Энэ бүлгийн судалгаанд оролцогч нараас шүүхийн шатлал тус бүрээр авлигын хэмжээ хэр байгааг асуухад Монгол Улсын дээд шүүх болон давж заалдах шатны шүүх хоёроос анхан шатны шүүх илүү их авлигад өртдөг гэж хариулжээ.

Монгол Улс “Авлигын төсөөллийн индекс 2022” үзүүлэлтээр авлига өсөж буй 10 орны нэгээр бичигджээ.

Ингэснээр манай улс авлигын индексээр 180 орноос 116 дугаарт жагссан нь сүүлийн 5 жилийн хамгийн муу үзүүлэлт гэдгийг “Транспэрэнси Интернэшнл Монгол” ТББ мэдээлэв.

Монгол Улс авлигын индексээр 2017 онд 36 оноо авч, 180 улсаас 103 дугаарт, 2018 онд 93 дугаарт, 2019 онд 106 дугаарт, 2020 онд 111 дүгээрт, 2021 онд 110 дугаарт, 2022 онд 116 дугаар байрт эрэмбэлэгдсэн байна.

Зураг 4. Транспэрэнси интернэшнл байгууллагын авлигын индексийн судалгаа мэдээлэл 2017-2021 он хүртэл¹¹

АВЛИГЫН ИНДЕКС 2021 ОНД 35 ОНОО АВЧ 116 БАЙРАНД ЖАГСАЖ БАЙВ.



**АВЛИГЫН
ИНДЕКС
2022**

МОНГОЛИА




33/116

AVERAGE SCORE RANK



СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН ОНОО



¹¹ <https://montsame.mn/mn/read/312175>



Манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлигын нөлөө хэр зэрэг байдгийг график 39-өөр харуулав.


Түүнчлэн хамгийн их авлигатай 11 байгууллагыг жагсаавал шүүх 2 дугаарт орж байна.

Зураг 5. Шударга байдлын үнэлгээ институцаар

№	Төрөл	2016	2018	2019	2021
1	Эрүүл мэндийн байгууллага	44.7%	46.4%	42.6%	48.3%
2	Шүүх	38.6%	49.2%	53.3%	48.0%
3	Газрын алба	46.4%	47.0%	42.9%	41.8%
4	Гаалийн байгууллага	37.7%	35.4%	48.0%	36.9%
5	Цагдаагийн байгууллага	30.9%	38.2%	33.9%	35.3%
6	Мэргэжлийн хяналтын байгууллага	32.2%	33.9%	44.6%	33.4%
7	Боловсролын байгууллага	30.5%	41.0%	32.9%	32.7%
8	Төрийн захиргааны байгууллага яам, агентлаг	33.0%	43.9%	35.0%	31.7%
9	Улс төрийн нам	31.5%	35.8%	33.7%	30.5%
10	Прокурорын байгууллага	22.3%	29.9%	33.2%	29.8%
11	Татварын байгууллага	24.0%	25.2%	26.7%	26.5%

Зураг 6-аас 2023 онд “Системийн динамик загварчлал” ТББ-ийн гүйцэтгэсэн “Монгол Улсын авлигын төсөөллийн индекс” судалгаагаар шүүхийн салбарын авлигын түвшин өсөх хандлагатай харагдаж байна. Иймд шүүх эрх мэдлийг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах нөхцөл байдал хэвээр байгаа нь харагдаж байна. Мөн тус судалгааны дүгнэлтээр авлигын гэмт хэргийг шүүх болон прокурорын шатнаас мөрдөн байцаалтад дахин буцаах, гэмт хэргийг мөрдөн шалгаж буй хугацаанд болон шүүхийн шатанд зориуд удаашруулах зэрэг асуудлыг болиулах хэрэгтэй байна гэжээ.¹²

Зураг 6. Шүүхийн салбарын авлига, загварын динамик тооцооллоор



¹² “Монгол Улсын авлигын төсөөллийн индекс”, “Системийн динамик загварчлал” ТББ, хуудас-37, Улаанбаатар хот, 2023 он.



График 40. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ? /Давхардсан тоогоор 229 хариултыг 100 хувь гэж үзэн шинжилгээ хийв./



Шүүхийн талаарх мэдээллийг фейсбүүк, шүүхийн байгууллагын албан ёсны сайт болон телевизээр олон нийтэд хүргэх нь мэдээлэл түгээх сувгуудаас хамгийн хүртээмжтэй, үр дүнтэй арга гэж хариулсан байна.

График 41. Олон нийтийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ? /Давхардсан тоогоор 179 хариулт байна./





Иргэд эрх зүйн талаарх мэдээллээр хангагдсанаар өөрийн болон бусдад зөрчигдсөн эрхээ хэрхэн хамгаалах талаар буюу шүүхэд хандах мэдлэг, мэдээлэл өргөжиж, шүүхэд итгэх итгэл нэмэгдэх болно.

Иймд иргэдийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд шүүхийн байгууллагын албан ёсны сайтыг сайжруулах, хандалт өндөртэй сошиал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх болон олны анхаарал татсан хэргийн шүүх хуралдааны бичлэгийг хураангуйлж, мэргэжлийн тайлбарын хамт олон нийтэд түгээх ажлуудыг хийх шаардлагатай.

Мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь албан бичиг, хийгдэж буй ажиллагаа аль үе шатанд явж байгааг мэдээлэх болон хэргийн оролцогч нарт тулгардаг нийтлэг асуудлыг судалж, судалгаанаас гарч ирсэн асуудлыг шийдвэрлэх цахим платформ хийх шаардлагатай байна.

Эрх зүйн хүрээний хөндлөнгийн судлаачид, багш нар шүүхийн шийдвэрүүдэд анализ хийж, энэ хүрээнд сургалт, судалгааны эх сурвалж болгон ашиглах мөн түүнчлэн хуульд нөлөөлөхүйц бүтээлийг гаргах шаардлага үүсээд байна.

График 42. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд хэр зэрэг нээлттэй, ил тод байдаг вэ?



Энэ хэсгийн судалгаанд оролцогчдын олонх нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд зарим талаараа нээлттэй байдаг гэжээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

**ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДААС АВСАН
СУДАЛГААНЫ ҮР ДҮН**





ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхийн захиргааны албан хаагчдаас авсан судалгааны үр дүнг энэхүү 3-аар бүлгээр танилцуулах болно.

Энэ бүлгийн асуумжид нийт 639 албан хаагч хамрагдсан бөгөөд албан тушаалаар нь задлан дараах 43-аар графикт харуулав.

График 43 . Албан тушаал:




График 44. Аль шатны, ямар хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд ажилладаг вэ? Давхардсан утгаар






График 45. Оролцогчдын нас болон ажилласан жилийг харуулав.



Нийт 639 шүүхийн захиргааны албан хаагчдаас 30 хүртэлх насны болон 31-40 насныхан дийлэнх хувийг эзэлж байна.

Харин ажилласан жилийн хувьд дийлэнх хувийг 7-оос дээш жил ажилласан шүүхийн захиргааны албан хаагчид эзэлсэн нь харагдаж байна.


График 46. Таны бодлоор шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэл хэр үр дүнтэй явагдаж байна гэж бодож байна вэ?



Шүүхийн захиргааны ажилчдын хувьд шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэлийн үр дүнг зарим талаараа үр дүнтэй байна гэж олонх нь үзэж байна.

Гэхдээ нийт шүүхийн захиргааны ажилчдын хувьд шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэлийн ажил үр дүнгээ өгч байгаа нь trendline-аар харагдаж байна.

График 47. Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа ажлуудтай Та санал нийлэх үү?



Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа үндсэн 5 ажлаас шүүхийн цахимжилтын ажил хамгийн үр дүнтэй хэрэгжиж байна. **График 48. Хэрэв та дээрх бодомжуудтай санал нийлэхгүй байвал. Яагаад санал нийлэхгүй байгаа шалтгаанаа энд бичнэ үү.**



Ажлын орчин нөхцөл муу, ажлын ачаалал их, цалин бага, нийгмийн баталгаа муу учраас шүүхийн шинэтгэл хангалттай хэрэгжиж байна гэж үнэлсэн байна.

График 49. Та дараах шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?




Шүүхэд ирэх хэрэг, маргааны тоонд гэнэтийн, огцом өөрчлөлт бий болбол шүүх түүнийг даван туулах хангалттай нөөц, бололцоогоор хангагдсан байдаг гэсэн бодомжтой энэ хэсгийн судалгаанд оролцогчдын 30 хувь нь зарим талаараа санал нийлж байна гэж хариулсан байна.

Харин шүүх шаардлага хангасан байранд байрладаг бөгөөд ажиллахад хангалттай өрөө, тасалгаа, зай талбайтай байдаг гэсэн бодомжтой олонх нь санал нийлэхгүй байна.

Шүүхэд хэрэгцээт мэдээллийн тоног, төхөөрөмж нь хангалттай байдаг гэсэн бодомжтой оролцогчдын олонх нь зарим талаараа санал нийлж байна гэжээ.

График 50. Та дараах шүүгчтэй холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?




Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх хараат бус, нээлттэй тогтолцоо бүрдсэн болон шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх



хараат бус, шударгаар явагддаг гэсэн бодомжуудтай оролцогчдын олонх нь санал нийлж байна.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүнтэй механизм, нөөц бололцоо бүрдсэн болон шаардлагатай үед шүүгч болон түүний гэр бүлийн гишүүдийн хувийн аюулгүй байдлыг хангадаг гэсэн бодомжуудтай зарим талаараа санал нийлнэ гэжээ.

График 51. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?



Энэ хэсгийн оролцогч нар Анхан шатны шүүхийг Монгол Улсын дээд шүүх болон давж заалдах шатны шүүхүүдээс авлигын нөлөө бага байдаг гэжээ.

График 52. Та дараах шүүхийн захиргааны ажилчидтай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?





График 52-оор шүүхийн захиргааны ажилчидтай холбоотой бодомжуудаас шүүхийн захиргааны ажилчдын багаар ажиллах чадвар хангалттай сайн гэжээ. Харин шүүхийн захиргааны ажилчдын хувьд цалин хөлс нь бусад орлогын эх



үүсвэр ашиглахгүйгээр ажиллаж, амьдрахад нь хүрэлцээтэй, тогтвортой ажиллахад хангалттай биш гэж хариулсан байна.

2021 оны 01 сарын 14 өдрийн Монгол Улсын их хурлын 3 дугаар тогтоолоор 1.2.шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын үндсэн цалингийн хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хоёр дахин нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна. Цаашид ч мөн адил шүүн таслах ажиллагааг тогтвортой явуулахын тулд бусад шүүхийн захиргааны ажилчдын цалинг нэмэх арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.


График 53. Та дараах удирдлагатай холбоотой бодомжуудтай санал нийлэх үү?



Шүүхийн захиргааны удирдлагуудын ажлын үр чадвар болон харилцааны зэрэг тус 53-аар графикаар харуулсан чадваруудад сайн гэсэн үнэлгээ дийлэнх хувийг эзэлж байна.



График 54. Таны бодлоор захиргааны ажилчдын ажлын гүйцэтгэлийг илүү сайжруулахын тулд аль бодомж дээр илүү анхаарч ажиллах ёстой вэ?



Шүүхийн захиргааны ажилчдын гүйцэтгэлийг сайжруулахын тулд нэн яаралтай шүүхийн захиргааны ажилчдын нийгмийн баталгааг мөн шүүхийн захиргааны ажилчдын цалин, урамшууллын системийг сайжруулах шаардлагатай байна.


График 55. Таны бодлоор захиргааны ажилчдыг чадавхжуулахын тулд аль бодомж дээр илүү анхаарч ажиллах ёстой вэ?



Шүүхийн захиргааны ажилчдын чадавхжуулахын тулд нэн яаралтай хүний нөөцийн орон тооны асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй гэжээ. Үүний дараа захиргааны ажилчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг болон шүүхийн шинэтгэлийн тухай хуулийг дахин харах шаардлагатай гэсэн байна.



График 56. Таны бодлоор шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарт ямар төрлийн хэрэг маргаан хамгийн их ачаалал үүсгэдэг вэ?



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хамааралтай шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарын хувьд иргэний эрх зүйн маргаан хамгийн их ачаалал үүсгэдэг бол удаах нь зээлийн маргаан /банк, СӨХ-тэй холбоотой маргаан/ мөн олон оролцогчтой хэрэг ачаалал үүсгэдэг байна.

Түүнчлэн шүүгч, шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нарт дараах төрлийн хэрэг маргаан, асуудлууд хамгийн их ачаалал үүсгэдэг бөгөөд шүүхийн захиргааны ажилчдаас ирсэн 358 саналыг агуулгаар нь багцлан 12 бүлэг болгон саналуудыг өнгөөр ялган харуулав. Үүнд:

Цахимжуулалтай холбоотой шүүхийн ачааллын талаарх санал

1. Цахим системээр хэрэг хуваарилахад ачааллыг тэнцвэржүүлэх боломжгүй ачаалал ихтэй байгаа шүүгч дээр дахин хэрэг хуваарилах мөн цахим системийн гацалт зэргээс үүдэж шүүгчийн туслах нэг ажлаа 2 дахин хийх зэрэг нь ачаалал үүсгэж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нарийвчилсан журмын зарим нэг ойлгомжгүй зүйлээс болж ачаалал үүсдэг.

Өмгөөлөгчтэй холбоотой шүүхийн ачааллын талаарх санал

2. Аль ч төрлийн хэрэг маргаанаас илүүтэйгээр өмгөөлөгч нар хэргийн материалтай ирж танилцахгүй байх, хурал болоход зайлшгүй бус шалтгаанаар хурал хойшлуулах нь ачаалал үүсэх шалтгаан болдог. Хэргийг хойшлуулахдаа хойшлуулах хүсэлтийн хамт хэрэгт хамааралгүй баримттай өгдөг. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй л бол ачаалал жигд байх боломжтой.

Олон нийтийн хандлагатай холбоотой шүүхийн ачааллын талаарх санал

3. Ачаалал үүсгэхээс илүүтэйгээр хүмүүсийн харилцаа хандлага туслах, шүүгч нарыг маш их стрессийг үүсгэдэг. Жишээ нь: Шүүх бол авлига авдаг газар, Монгол улсын шүүх бол хог, туслахууд бол шүүгчийн боол гэх мэтээр шүүхэд дайрах хандлага их байдаг. Иймд хэл амгүй, хэрүүл тэмцэлгүй, тайван ажлаа хийх боломжоор хангаж өгөх хэрэгтэй. Шүүхийг зөвлөгөө өгдөг байгууллага мэтээр ойлгож, хууль зүйн үйлчилгээ үзүүлэхийг шаардаж байгаа нь ачааллыг нэмэгдүүлдэг.

Шүүх бол гуравдагч засаглал учраас олон нийт шүүхийн байгууллагыг хүндэлдэг ёс суртахуунтай байх ёстой. Үүний тулд шүүхийн талаарх ойлголт, зөв хандлагыг нийгэмд бий болгох ажлыг ШЕЗ хэрэгжүүлэх хэрэгтэй. Жишээ нь: Шүүхэд хандсан иргэдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тайлбарлахад нэн хүндрэлтэй ойлгодоггүй. Иймд иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх үүднээс нэн яаралтай бодлого болох.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой шүүхийн ачааллын талаарх санал



4. Олон газар нутгийг хамарсан ашигт малтмал, төрийн захиргааны байгууллагаас гэнэт гаргасан шийдвэрүүд болон төлөвлөлтгүй гаргасан шийдвэртэй холбоотой аливаа маргаанууд ачаалал их үүсгэдэг. Гэхдээ эдгээр маргаануудын дийлэнхийг нь хоорондоо зохицох боломжтой маргаан байдаг.

Сум дундын шүүхтэй холбоотой шүүхийн ачааллын талаарх санал

5. Сум дундын шүүхүүд нь эрүү, иргэн, зөрчил, өргөдөл гомдол, ТСАХ, ШШГХ ажиллагаа гээд бүх төрлийн хэрэг маргаан авдаг учир энэ нь ачаалал үүсгэдэг. Дагнасан шүүх болох нь ажлын ачаалал бууруулна

Шүүхийн ачааллыг бууруулж боломжтой гэсэн санал

6. Банк бус санхүүгийн байгууллага, Скайтел, Жи-мобайл, Мобиком, Юнител ХХК нараас ирж буй нэхэмжлэлүүд нь ихэнхдээ 1 саяас доош төгрөг байдаг бөгөөд тэд нэхэмжлэл өгөхдөө 40, 50-аар нь оруулж ирдэг. Иймд 1 саяас доош үнийн дүнтэй нэхэмжлэлүүдийг эвлэрүүлэн зуучлагч нар авбал шүүхийн ачаалал тодорхой хэмжээгээр буурах болно.

7. Эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудсыг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг шүүх хүлээн авдаг. Мөн шийтгэлийн хуудсыг өөрчлөх, хүчингүй болгох материалуудыг хүлээн авахыг болиулах хэрэгтэй.

Төвийн дүүргийн шүүхийн захиргааны албан хаагчаас ирсэн санал

8. Төвийн дүүрэг учраас хэргийн өнгө өөр, шүүхээр үйлчлүүлж байгаа иргэдийн хуулийн мэдлэг өндөр байдаг тул хуулийн гаргалгааг маш сайн мэддэгээс үүдэн шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт маш их ирдэг. Үүнээс үүдэн хэрэг шийдвэрлэгдэх хугацаа удааширч хэргийн үлдэгдэл ихсэх, мөн шүүхийн шүүх хуралдааны заалны хүрэлцээ муу байдаг.

Зөрчлийн хэрэг маргаатай холбоотой шүүхийн ачааллын талаарх санал

9. Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа ачаалал үүсгэдэг учир нь ажлын 3 хоногт шүүх хуралдаан товлон зарладаг. Шүүгч нар ээлжийн амралт авсан үед үлдсэн шүүгчид ачаалал үүсдэг.

10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой шүүхийн ачааллын талаарх санал

- Эрүүгийн шүүхийн хувьд зөрчил болон цагдан хорио ачааллыг маш ихээр нэмэгдүүлдэг.
- Эрүүгийн хэргүүдийн хувьд олон оролцогчтой, олон хавтас бүхий хэргүүд ачаалал үүсгэдэг.
- Хялбаршуулсан журмаар ирүүлж байгаа эрүүгийн хэргийг заавал шүүхээр шийдүүлэхгүйгээр өөр шатны байгууллага эсвэл тусгайлсан шүүх байгуулбал ачаалал үүсгэхгүй байх боломжтой гэж харж байна
- Шүүгч нар зөвхөн эрүүгийн хэргээр дагнан ажиллахгүй, зөрчлийн хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээний гомдол, санал шийдвэрлэх, ял солих хурал зэрэг хурлуудад ордог нь тодорхой хэмжээгээр ачаалал үүсгэдэг.
- Сүүлийн жилүүдэд олноор гарч буй Финтек зээл буюу Гар утасны аппликейшнаар олгогддог Банк бус санхүүгийн байгууллагуудын зээл, Банкны зээл, Үүрийн телефоны өр төлбөрийг нэхэмжлэл шүүхэд илт ачаалал үүсгэдэг.
- Залилангийн хэрэг маш их хохирогчтой тул хохирогч тус бүрт хүрч ажиллахад хүндрэлтэй. Эрхийн актыг маш их тоогоор гаргаж байгаа нь ач холбогдолгүй маш их бичиг цаасны зардал болон ажил болдог, зөрчлийн хэрэг, эрх бүхий албан тушаалтны шийтгэвэр баталгаажуулах ажиллагаа бүрийг шүүхэд авчирдаг нь учир дутагдалтай. Жишээлбэл: 10,000 төгрөгөөр торгосон шийтгэврийн биелэлтийг хангахын тулд цагдаа, прокурор, шүүх, ШШГГ нийт 4 байгууллагаас 2-3 хүн ажиллаж байгаа нь ажлын ачаалал, бичиг цаасны зардлыг ихэсгэж байна. Эцсийн дүнд 10,000 төгрөгийг торгуулийг төлүүлэхийн тулд 4 байгууллагаас 10 гаруй төрийн албан хаагч ажиллаж 30-40 хуудас бүхий хэрэг болгон үдэж архивлаж байгаа нь цаг хугацааны болон зардал чирэгдэл ихтэй байгаад зохицуулалт шаардлагатай. Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, хялбаршуулсан хэргүүдийн ажиллагаа зардал ачааллыг багасгах хуулийн зохицуулалт хийх шаардлага үүсээд байна.



Шүүгч болон шүүгчийн туслах, нарийн бичиг нарын орон тоог нэмэгдүүлснээр шүүхийн ачаалал буурна. Тодруулбал:

11. Хэрэг маргааны төрөл гэхээсээ илүү шүүгчийн орон тоог бүрэн гүйцэд ажиллуулахад л ачаалал буурна. Ямар ч хэрэг маргаан орж ирж болзошгүй болохоор ачааллыг л хурдан бууруулна. Бодит байдал дээр нарийн бичгийг өөр дүүргийн шүүх хуралдаанд оруулах, үүнээс болж үлдэж хоцорсон нэгэнд нь ачаалал ирдэг. Заримдаа удаан ажилласан туршлагатай гэдгээрээ илүүл ачаалал авдаг.
12. Монгол Улсын хэмжээнд иргэний хэргийн шүүхийн ачаалал маш өндөр байдаг. Эрүүгийн хэргийн зарим шүүх ачаалал ихтэй ч иргэний шүүх шиг хэргийг анхнаас нь боож баглаад нотлох баримт бүрдүүлэх шаардлагагүй. Иргэний шүүхийн шүүгч, шүүгчийн туслахын орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байдаг. 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүх байлаа гэж бодоход нэг шүүгчийг сэлгэн ажиллуулах эсхүл татгалзан гаргасан тохиолдолд шууд бүрэлдэхүүний асуудал босоод ирдэг. Өөр шүүхээс бүрэлдэхүүн дуудахаас өгсүүлээд хүндрэлүүд маш их байдаг. Сум дундын шүүхүүд дор хаяж 4 шүүгчтэй болсон тохиолдолд бүрэлдэхүүний асуудал арай дээрдэнэ. Мөн шүүгчийн ачаалал ч тэр хэрээр багасна. Шинээр томилогдож байгаа шүүгч нар өөр орон нутгаас ирэх маш хүндрэлтэй. Томилогдоод удаагүй сэлгэн ажилламаар байна гээд яваад өгдөг. Иймд шинээр томилогдох шүүгч нарыг томилохдоо нөхцөл байдлыг харгалзан үздэг баймаар байна. Адаглаад эхний 1-2 жилд сэлгэн ажиллах талаар март гэдэг ч юм уу. Арай гэж бүрэлдэхүүн гүйцлээ гэтэл нөгөө шүүгч нь яваад өгнө. Хойд хормойгоороо урд хормойгоо нөхсөөр л явна.

Шүүгчийн ажлын ачааллыг тооцсон жишиг шалгуурыг оновчтой тогтоогоогүй. Тодруулбал:

13. Шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлын ачааллыг олон оролцогчтой, олон хавтастай хэрэг хамгийн их ачаалал үүсгэхээс гадна мөн хавтасны тоо, хэргийн оролцогчийн тооноос үл хамааран маргааны үйл баримт ээдрээтэй, төвөгтэй оролцогч талууд хэргийн үйл баримт, гэм буруу, хохирол хор уршгийн асуудалд маргаан ихтэй хэргүүд нь тухайн хэргийн шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа, шүүх хуралдааны үргэлжлэх хугацаа, шүүхийн шийдвэр гардуулах, болон шийдвэрлэсний дараах ажиллагаануудаас шалтгаалан шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргад их ачаалал үүсгэдэг. Харин хүлээн авч буй хэрэг, шийдвэрлэж буй хэргийн тоогоор ачааллыг тодорхойлох нь учир дутагдалтай.
14. Шүүхэд зөрчлийн хэрэг маш их ирдэг нэг шүүхэд нэг л зөрчлийн шүүгч, нэг туслах байдаг бөгөөд 7 хоногтоо 40-60 ирдэг энэ тохиолдолд нэг туслах зөрчлийн хэрэг хүлээж авна, шийдвэрээ бичнэ, программын бүртгэлд дугаар авна, хэргээ архивлана. Мөн хажуугаар нь цагдан хорио өдөрт 2-оос 4 орж ирнэ. Түүний хурлыг бэлтгэнэ захирамж гаргана, гомдол хүлээн авна. Мөн албадан гүйцэтгэх хуудас 7 хоногтоо 10-аас 40 орж ирдэг гүйцэтгэх хуудас захирамжийн хамт бичнэ. Эдгээрээс авч үзэхэд тухайн шүүхийн цагдан хорио, зөрчлийн шүүгчийн туслах хамгийн их ачаалалтай ажилладаг нь судалгаагаар болон практикаар та бүхэнд харагдаж байгаа байх. Би шүүхэд ажиллаад 10 гаран жил болж байна. Зөрчил болон хорионы туслах гэж тусдаа байхыг дэмжиж байна. Энэхүү судалгаагаар дамжуулан хүлээн авч зохих арга хэмжээг авах байх гэж найдаж байна.

Бусад

15. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын хувьд танхим, цахим хосолсон хурлын үед тэмдэглэл бичих боломж гардаггүй. Учир нь техникийн ажилтны үүрэг гүйцэтгэх шаардлага үүсдэг.
16. Олон хавтаст хэргээс гадна, дутуу ажиллагаа хийгдсэн хэрэг.
17. АТГ-с шилжүүлж буй хэргүүд мөн шүүхийн харьяалал зөрчиж ирүүлсэн хэргүүд ачаалал үүсгэдэг.



График 57. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?



Шүүхийн талаарх мэдээллийг фейсбүүк, шүүхийн байгууллагын албан ёсны сайт болон телевизээр олон нийтэд хүргэх нь мэдээлэл түгээх сувгуудаас хамгийн хүртээмжтэй, үр дүнтэй арга гэж хариулсан байна.

Хүснэгт 7. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй талаарх саналд нэг удаа давтагдаж буй саналыг харуулав

Дараах саналуудыг тус бүр нэг оролцогч ирүүлсэн байна.
Өмгөөлөгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх зэрэг бусад байгууллагуудтай хамтран нээлттэй өдөрлөг /хууль хэрэглээ, хэрэг хэрхэн шийдвэрлэгддэг талаарх болон ямар мэдээллийг хаанаас авч болох аргыг сурталчлан таниулах/ болон бусад төрлийн арга хэмжээ зохион байгуулах.
Утасны автомат хариулагчаар анхан шатны мэдээллийг өгдөг болгох хэрэгтэй.
Шүүх, шүүгчийг харлуулсан, нэр хүндэд нь халдсан шинжтэй мэдээ мэдээлэлд түргэн шуурхай арга хэмжээ авах. Жишээ нь: шийтгэл, торгуулийн хэмжээг нэмэх
Дүүргийн болон аймгийн шүүхүүд иргэдэд жилдээ 1-2 удаа сургалт зохион байгуулдаг болсноор иргэдийн шүүхийн талаарх мэдлэг нэмэгдэнэ.



График 58. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?



Шүүхийн захиргааны ажилчид иргэдийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд 1-рт хандалт өндөртэй социал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх, 2-рт шүүхийн байгууллагын албан ёсны сайтыг сайжруулах, 3-рт шүүх иргэдэд мэдээлэл өгдөг өөрийн гэсэн аппликейшнтай болох хэрэгтэй гэжээ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

**ШҮҮХ ХУРАЛДААНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ НАРААС
АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**





ШҮҮХ ХУРАЛДААНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ НАРААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч нараас авсан судалгааны үр дүнг энэхүү бүлэгт танилцуулах болно.

Энэ бүлгийн асуумжид нийт 177 ШХИТ хамрагдсан бөгөөд 45 хувь нь 2-6 сарын өмнө, 17 хувь нь 7-12 сарын өмнө, 35 хувь нь 1-2 жилийн өмнө харин үлдсэн 3 хувь нь энэ сард шүүх хуралд ШХИТ-өөр оролцсон байна.

ШХИТ-өөр оролцсон иргэдийн 95 хувьд нь шүүхтэй холбоотой ямар нэгэн хүндрэл бэрхшээл үүсээгүй байна.

График 59. Хэдэн сарын өмнө шүүх хуралд иргэдийн төлөөлөгчөөр оролцсон бэ?, Шүүх хуралд оролцоход ямар нэгэн асуудал гарсан уу?






График 60. Шүүхийн ажилтнуудын харилцаа, хандлагын үнэлгээг харуулав.



Шүүгчийн туслах, ШХНБД болон шүүгч нарын харилцаа, хандлага эелдэг, уриалгахан байсан гэсэн бол МЛМ, ШТГД, Эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлагчийн туслахтай харилцаж байгаагүй тул харилцаа хандлагыг хэлж мэдэхгүй байна гэжээ.



График 61. Шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч шүүх хуралдааны шийдвэртэй бүрэн санал нийлсэн эсэхийг болон Иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцсоноор шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдлэг нэмэгдүүлсэн эсэхийг харуулав.



Нийт 177 ШХИТ-өөс 162 буюу 92 хувь нь шүүх хуралдааны шийдвэртэй санал нийлсэн байна.

График 62. Иргэдийн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож байсан иргэдэд ямар нэгэн асуудал тулгарахад шүүхэд хандах эсэхийг харуулав.



ШХИТ-өөр ажиллаж байсан иргэдийн шүүхэд хандах итгэлийг хэмжихдээ тус иргэнээс ямар нэгэн асуудал тулгарахад шүүхэд хандах эсэхийг лавлаж асуусан бөгөөд тэдний 88 хувь нь шүүхэд хандана гэжээ.

График 63. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?



Энэ хэсгийн оролцогч нар Анхан шатны шүүхийг Монгол Улсын дээд шүүх болон давж заалдах шатны шүүхүүдээс авлигын нөлөө бага байдаг гэжээ.



График 64. Сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдсөн болохыг дан тоололтоор болон хэдийн сарын өмнө шүүх хуралд ШХИТ-өө сууж байсан хугацаагаар харьцуулан харуулав.



Сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагын үйл ажиллагааг сайжирсан гэж дүгнэж байна.

График 65. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд хэр зэрэг нээлттэй, ил тод байдгийг харуулав.



ШХИТ нарын олонх нь буюу 48 хувь нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд зарим талаараа нээлттэй гэж хариулсан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ

**ШҮҮХЭД ХАНДАЖ БАЙСАН ОЛОН НИЙТЭЭС АВСАН
СУДАЛГААНЫ ҮР ДҮН**





ШҮҮХЭД ХАНДАЖ БАЙСАН ОЛОН НИЙТЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шүүхэд хандаж байсан олон нийтээс авсан судалгааны үр дүнг энэхүү бүлэгт танилцуулах болно.

Энэ бүлгийн асуумжид нийт 282 иргэн хамрагдсан бөгөөд насны хувьд 25-44 насныхан, ажил эрхлэлтийн хувьд төрийн болон төсвийн, хувийн байгууллагад ажилладаг иргэд харин боловсролын хувьд бакалаврын болон дээд боловсролтой иргэд дийлэнх хувийг эзэлж байна.

График 66. Таны нас:




График 67. Таны ажил эрхлэлтийн байдал




График 68. Таны боловсролын түвшин:







График 69. Аль шатны шүүхэд хандаж байсан бэ? Давхардсан утгаар



Судалгаанд нийт 282 иргэнээс 281 буюу 99.6 хувь нь анхан шатны шүүхэд, 16.3 хувь нь давж заалдах шатны шүүхэд, 11.7 хувь нь Монгол Улсын дээд шүүхэд хандаж байсан байна.

График 70. Та ямар төрлийн хэрэг маргаанаар шүүхэд хандсан бэ? Давхардсан утгаар



Нийт 282 иргэний 184 иргэн иргэний шүүхэд, 36 иргэн захиргааны шүүхэд, 75 иргэн эрүүгийн шүүхэд харин 45 иргэн зөрчил хянан шийдвэрлэх асуудлаар тус тус эрүүгийн шүүхэд хандсан байна.

График 71. Та шүүх хуралдаанд ямар үүрэгтэй оролцсон бэ?





Шүүхээр үйлчлүүлсэн иргэдийг шүүх хуралдаанд ямар байдлаар оролцож байсныг задлан харвал олонх нь буюу 40.6 хувь нь нэхэмжлэгчээр, 13.3 хувь нь хохирогчоор, 10 хувь нь хариуцагчаар оролцсон байна.

График 72. Таны хувьд шүүхэд хандахад Таны шүүхэд итгэх итгэлийг бууруулсан тохиолдол гарч байсан уу?



Нийт судалгаанд оролцсон 282 иргэний 226 иргэнийн шүүхэд итгэх итгэл хэвээр байгаа бол 56 иргэний шүүхэд итгэх итгэл буурсан байна.

ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД СЭТГЭЛ ХАНГАЛУУН БУС ИРГЭДЭЭС АВАХ АСУУМЖИЙН ҮР ДҮН /ГРАФИК 73-75 ХҮРТЭЛ/

Шүүхийн үйлчилгээнд сэтгэл хангалуун бус байгаа иргэдээс аль шатны шүүхэд хандахад асуудал гарч байсныг тодруулахад 47 иргэний хувьд анхан шатны шүүх дээр, 18 иргэний хувьд давж заалдах шатны шүүх дээр, 7 иргэний хувьд Монгол Улсын дээд шүүх дээр асуудал үүсэж байжээ.

Харин хэргийн маргааны төрлийн хувьд их асуудал үүсдэг маргаан бол иргэний маргаан юм.

График 73. Ямар төрлийн хэрэг маргаанаар аль шатны шүүхийн үйлчилгээ Таны шүүхэд итгэх итгэлийг багасгаж байсан вэ? /Хэдэн сонголт ч хийж болно/ n=56






График 74. Тухайн үед Таны шүүхэд итгэх итгэл буурахад нөлөөлсөн хүчин зүйлс:



Шүүхээр үйлчлүүлэхэд шүүгч шударга бусаар хэргийг шийдвэрлэсэн гэж үзэх хандлага болон шүүгчийн харилцаа хандлага хамгийн ихээр шүүхэд итгэх итгэл буурахад нөлөөлдөг хүчин зүйл болж байна.


График 75. Тухайн үед асуудлыг ямар байдлаар, ямар аргаар шийдвэрлэсэн бол та сэтгэл хангалуун үлдэх байсан бэ?



Шүүхийн үйлчилгээнд сэтгэл хангалуун бус үлдсэн иргэдээс тухайн асуудлыг ямар аргаар шийдвэрлэсэн бол тухайн иргэд сэтгэл хангалуун үлдэх байсан эсэхийг тодруулахад хуулийг зөв хэрэглэх, хэргийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн дүгнэхгүйгээр шийдвэрийн үндэслэлийг сайн боловсруулаагүй. Түүнчлэн шүүгч шударга, үнэн зөв шийдвэр гаргаагүй учраас шүүхэд итгэх итгэл буурсан гэжээ.




График 76. Таны хандсан шүүх Таны асуудлыг хэдий хугацаанд шийдвэрлэж өгсөн бэ?



Нийт шүүхэд хандсан 282 иргэний 89 иргэн 1 сар хүртэлх хугацаанд, 77 иргэн 14 хоногийн дотор, 46 иргэн 1-2 сар хүртэлх хугацаанд асуудлаа шийдвэрлүүлсэн байна.

График 77. Таны хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн тухайн шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд нарийвчилсан үнэлгээ өгнө үү?



Нийт 282 иргэний тус 100 хувь гэж үзвэл шүүхийн шийдвэрийн ил тод байдал бусад 4 үйл ажиллагаанаас хамгийн сайн хэрэгжиж байна. Ерөнхийдөө хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн тухайн шүүхийн байгууллагын үйл ажиллагааг судалгаанд оролцогчдын олонх нь сайн гэж үнэлсэн байна.

График 78. Шүүхийн ажилтнуудын зан харилцааны соёлыг Та үнэлнэ үү.




Энгийн, эелдэг уриалгахан гэсэн хоёр үнэлгээг нэгтгэж шүүхийн ажилтнуудын харилцааны соёл сайн гэж харвал эвлэрүүлэн зуучлагч болон




шүүхийн Тамгын газрын дарга нараас бусад МЛМ, шүүгчийн туслах, ШХНБД, шүүгч нарын харилцаа, хандлага сайн гэсэн үнэлгээ авсан байна.

График 79. Шүүх нь таны үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэр хамгаалж байна гэж бодож байна вэ?



Шүүх нь шүүхэд хандаж байсан иргэдийн хувьд тэдний үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэр муу хамгаалж байна гэжээ.

График 80. Шүүхэд хандахад Танд ямар нэгэн бэрхшээл үүсэж байсан уу?



Шүүхэд хандаж байсан иргэдийн 21 хувь нь шүүхэд хандахад тодорхой хэмжээгээр хүндрэл бэрхшээл үүсэж байсан байна.




График 81. Дараах бэрхшээлүүдээс Таны хувьд хамгийн их асуудал үүсгэж байсан бэрхшээлийг сонгосон уу.



Шүүхэд хандахад хүндрэл бэрхшээл үүсэж байсан 58 иргэн буюу нийт судалгаанд оролцогчдын 21 хувьд нь санхүүгийн бэрхшээл, цахимаар шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл авах боломж байхгүй ба цаг хугацаа их зарцуулагдсан гэсэн хүндрэл бэрхшээл хамгийн их үүсдэг байна.




График 82. Сүүлийн хоёр жилийн хугацаанд шүүхийн байгууллагын үйл ажиллагаа хэрхэн өөрчлөгдөж байна вэ?



Шүүхэд хандаж байсан иргэд сүүлийн хоёр жилийн хугацаанд шүүхийн байгууллагын үйл ажиллагаанаас шүүхийн үйлчилгээний орчин бусад үйл ажиллагаанаас илүү их сайжирсан гэжээ.

График 83. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ? N=282



Шүүхийн шатлалаар шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байгааг харьцуулан харахад Монгол Улсын дээд шүүхэд давж заалдах шатны шүүх, анхан шатны шүүхээс хоёроос илүү их авлига нөлөөлж байна гэж хариулжээ.



График 84. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?



Шүүхийн талаарх мэдээллийг фейсбүүк, телевиз болон мэдээллийн сайтаар олон нийтэд хүргэх нь мэдээлэл түгээх сувгуудаас хамгийн хүртээмжтэй, үр дүнтэй арга гэж хариулсан байна.

График 85. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?




Иргэдийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд хандалт өндөртэй социал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх, шүүхийн байгууллагын албан




ёсны сайтыг сайжруулах болон шүүхийн тоймыг тогтмол хүргэх ажлыг хийх шаардлагатай.

График 86. Шүүхээр үйлчлүүлэхэд шаардлагатай лавлагаа, мэдээллийг цахимаар авч байсан уу?



Шүүхээр үйлчлүүлэхэд шаардлагатай лавлагаа, мэдээллийг цахимаар авч байсан эсэхийг тодруулахад энэ бүлгийн судалгаанд оролцогчдын 51 хувь нь авч байсан, 41 хувь нь авч байгаагүй гэсэн бол 8 хувь нь цахимаар авах гэсэн боловч цахимаар шаардлагатай лавлагаа, мэдээллээ хэрхэн авахаа мэдэхгүй байсан гэжээ.

График 87. Хэрэв тийм бол лавлагаа мэдээллийг цахимаар авахад хэр боломжийн санагдсан бэ?



Цахимаар үйлчилгээ авч байсан 143 иргэнийг 100 хувь гэж үзэн лавлагаа мэдээллийг цахимаар авахад хэр боломжийн санагдсан болохыг лавлахад 30 хувь нь маш боломжийн, 55 хувь нь боломжийн, 13 хувь нь зарим талаараа асуудалтай гэсэн бол үлдсэн 3 хувь нь төвөгтэй санагдсан гэж хариулсан байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

**ШҮҮХЭД ХАНДАЖ БАЙГААГҮЙ ОЛОН НИЙТЭЭС АВСАН
СУДАЛГААНЫ ҮР ДҮН**






ШҮҮХЭД ХАНДАЖ БАЙГААГҮЙ ОЛОН НИЙТЭЭС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлгийн асуумжид нийт 167 шүүхэд хандаж байгаагүй иргэн хамрагдсан бөгөөд судалгааны үр дүнг энэхүү бүлэгт танилцуулах болно.

График 88. Судалгаанд оролцогчдын нас



Шүүхэд хандаж байгаагүй, судалгаанд хамрагдсан иргэдээс 25-34 насныхан идэвхтэй оролцсон буюу 41%-ийг эзэлж байна. 55-аас дээш насны иргэд болон 18 хүртэлх насны иргэд хамгийн цөөн буюу тус бүр 2%-ийг эзэлж байна.

График 89. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин





График 89-өөс харахад судалгаанд хамрагдсан оролцогчдын 61 хувь нь бакалавр болон дипломын дээд боловсролтой, 20 хувь нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй, 13 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол үлдсэн 6 хувь нь тусгай дунд, бүрэн бус дунд, хариулахаас татгалзсан гэх хариултыг өгсөн байна.




Үүнээс харахад судалгаанд оролцож буй иргэдийн боловсролын түвшин харьцангуй өндөр байгааг харуулж байна.

График 90. Таны хувьд шүүхэд хандах ямар нэгэн асуудал гарч байсан уу?



Энэхүү бүлгийн судалгаанд оролцогч нарын 31 хувьд нь шүүхэд хандахад асуудал үүсэж байсан бөгөөд насны бүлэг тус бүрийг 100 хувь гэж үзэхэд 35-44 насны иргэдийн 36 хувьд нь, 25-34 насны иргэдийн 28 хувьд нь, 18-24 насны иргэдийн 22 хувьд нь 55-аас дээш настай иргэдийн 50 хувьд нь, 45-54 насны иргэдийн 54 хувьд нь шүүхтэй холбоотой хүндрэл бэрхшээл үүсэж байсан байна.

График 91. Тийм бол та шүүхэд хандсан уу? N=51



Шүүхэд хандах нөхцөл байдал үүсэж байсан 51 иргэний 35 нь буюу 69 хувь нь шүүхэд хандаж байсан байна.

Харин шүүхэд хандах нөхцөл байдал үүсэж байсан ч шүүхэд хандаагүй гэсэн 16 иргэнээс ямар шалтгаанаар шүүхэд хандаагүй болохыг лавлахад нэхэмжлэх мөнгөн дүн бага учраас шүүхэд хандаагүй, тухайн асуудал хараахан шүүхийн шат руу шилжих эсэх нь тодорхойгүй байгаа болон ойр тойрны хүмүүс шүүхэд хандах шаардлагагүй гэсэн хариултыг олонх нь сонгосон байна.



График 92. Та ямар асуудлаас болоод шүүхэд хандаагүй вэ? n=16



График 93. Таны бодлоор манай улсын шүүгчид ёс зүйн хэм хэмжээг хэр зэрэг сахидаг вэ?





График 93-аас харахад шүүхэд хандаж байгаагүй гэсэн иргэдийн 29 хувь нь буюу олонх нь шүүгчид ёс зүйн хэм хэмжээгээ дунд зэрэг сахидаг гэжээ.

График 94. Таны бодлоор манай улсын шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр зэрэг нөлөөлж байна вэ?



Энэ бүлгийн судалгаанд оролцогч нараас шүүхийн шатлал тус бүрээр авлигын хэмжээ хэр байгааг асуухад анхан шатны шүүх болон давж заалдах




шатны шүүх хоёроос Монгол Улсын дээд шүүх илүү их авлигад өртдөг гэж хариулжээ.

График 95. Таны бодлоор шүүх нь таны үндсэн хуулиар олгогдсон эрхийг хэр хамгаалж байна гэж бодож байна вэ?




Шүүхэд хандаж байгаагүй иргэдийн 29 хувь нь буюу олонх нь үндсэн хуулиар олгогдсон эрхээ шүүхээр тодорхой хэмжээнд хамгаалуулж чадаж байна гэжээ.

График 96. Та шүүхийн үйл ажиллагаа болон шүүгч нартай холбоотой мэдээллийг хэр их хангалттай мэдээлэл авдаг вэ?



Шүүхийн үйл ажиллагаа болон шүүгч нартай холбоотой мэдээллийг хангалттай авч чаддаггүй гэсэн байна.

График 97. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд хэр зэрэг хангалттай, ил тод байдаг вэ?



Шүүхэд хандаж байгаагүй иргэд шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд зарим талаараа нээлттэй байдаг гэжээ.



График 98. Шүүхийн талаарх мэдээллийг аль сувгаар олон нийтэд хүргэвэл илүү хүртээмжтэй, үр дүнтэй вэ?



Шүүхийн талаарх мэдээллийг **фейсбүүк**, мэдээллийн сайт болон телевизээр олон нийтэд хүргэх нь мэдээлэл түгээх сувгуудаас хамгийн хүртээмжтэй, үр дүнтэй арга гэж хариулсан байна.





График 99. Олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд дараах хувилбаруудаас аль нь илүү үр дүнтэй, хүртээмжтэй арга гэж бодож байна вэ?



Иргэдийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд хандалт өндөртэй социал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх, шүүхийн байгууллагын албан ёсны сайтыг сайжруулах болон олны анхаарал татсан хэргийн шүүх хуралдааны бичлэгийг хураангуйлж, мэргэжлийн тайлбарын хамт олон нийтэд түгээх хэрэгтэй гэжээ. Мөн иргэд шүүхийн байгууллагаас залилангийн гэмт хэргийн тухай, газар өмчлөлийн тухай болон хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн мэдээллийг авах хүсэлтэй байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ

**ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТНУУДААС АВСАН
СУДАЛГААНЫ ҮР ДҮН**






ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН ОЮУТНУУДААС АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ бүлэгт хууль зүйн сургуулийн 35 оюутан оролцсон бөгөөд судалгааны үр дүнг энэхүү бүлэгт танилцуулах болно.

График 100. Судалгаанд оролцогчдын нас, Та хэд дүгээр курсийн оюутан бэ?



Судалгаанд ИЗОУИС-ийн Их засаг хууль зүйн сургуулийн 21 оюутан, Шихихутуг ИС-ийн Хууль зүйн сургуулийн 8 оюутан, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 6 оюутан оролцсон байна.

График 101. 3. Та ямар салбар эрх зүйгээр мэргэшиж, мэргэших бодолтой байна вэ?





График 102-оос харахад 35 оюутны олонх нь буюу 12 нь иргэний эрх зүйгээр, 7 оюутан эрүүгийн эрх зүйгээр мэргэжих бодолтой байна гэжээ.



График 102. Шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд авлига хэр нөлөөлж байгаа эсэх:



Энэ бүлгийн судалгаанд оролцогч нараас шүүхийн шатлал тус бүрээр авлигын хэмжээ хэр байгааг асуухад анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх хоёроос Монгол Улсын дээд шүүхэд авлигын нөлөө их байгаа гэж олонх нь хариулжээ.

График 103. Шүүх нь таны үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаалж чадаж байгаа эсэх:



Нийт оюутнуудын 15 нь буюу дийлэнх нь үндсэн хуулиар олгогдсон эрхээ шүүхээр хангалттай сайн хамгаалуулж чадахгүй байна гэжээ.

Хүснэгт 8. Оюутан Таны бодлоор манай улсын шүүх эрх мэдлийг хараат бус, бие даасан тогтолцоог бүрдүүлэхийн тулд юуг өөрчилбөл илүү сайжрах вэ?

Авлигын асуудлыг шийдвэрлэх	6
Шүүхийн байгууллага нь цалин болон ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	3
Шүүхийн тогтолцоог өөрчлөх	3
Шүүхийн төсвийн зарцуулалтыг шилэн данстай болгох	2
Шүүх нь тусдаа бие даасан төрөөс үл хамаарах байвал зохино. Тодруулбал шүүгчийг ерөнхийлөгч томилох хуулийн заалтыг хэрэгсгэхгүй болгох хэрэгтэй	2
Хууль баталж байгаа эрх мэдэлтнүүд болон цагдаа, шүүгч нартаа шалгалт хийж олсон хууль бус орлогыг нь төрийн өмч болгож, ажлаас нь чөлөөлөх. Мөн шүүхийн байгууллагын ёс зүй, хариуцлагын тогтолцоог сайжруулах хэрэгтэй	1
Хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй.	1
Эрүүгийн шүүхийн үйл ажиллагааг хурдан шуурхай явуулах зорилгоор гомдолгүй болсон хэргүүдийг прокурор дээр хааж, шүүхээр оруулахыг зогсоох нь зүйтэй.	1
Эрх мэдэлтнүүдийн гар хөл болсон шүүгч нарыг солих	1
Шүүгчдийн ажлын ур чадварыг сайжруулах шаардлагатай	1
Шүүгч нарын сонгон шалгаруулалтыг сайжруулах арга хэмжээ авах нь зүйтэй	1
Шүүхийн байгууллагын ажиллах боловсон хүчнийг залуу чадварлаг боловсон хүчнээр сэлбэх	1
Хууль зохиогч, батлагч хүмүүсийг нэн тэргүүнд өөрчлөх шаардлагатай	1
Шүүгчийг тодорхой хугацаагаар томилж ажиллуулах	1
Шүүгч нарт сэтгэл зүйн сургалт болон үйлчилгээг үзүүлдэг болох хэрэгтэй	1



Шүүгчид ногдуулах хуулийн хариуцлагыг чанга болговол илүү үр дүнтэй мөн шүүх эрх мэдэлд цахим орчин их нөлөөлж байгаа учир энэ тал дээр удирдах албан тушаалтнууд анхаарч ажиллах шаардлагатай	1
--	---

Одоо байгаа шүүхийн тогтолцоог өөрчилж, шүүхийн байгууллагын цалин болон ажиллах орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай байна. Бөгөөд үүний тулд шүүхийг эдийн засгийн хувьд бие даах, улс төрөөс хараат байснаар манай улсын шүүх эрх мэдэл хараат бус, бие даасан тогтолцоо бүрэлдэнэ гэжээ.

График 104. Шүүхийн тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байсан оюутнуудын хувьд: n=12




Шүүхийн тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байсан оюутнуудаас шүүхийн талаарх бодомжуудыг асуухад тэдний ажигласнаар шүүхэд хэрэгцээт мэдээллийн тоног, төхөөрөмж нь хангалттай байдаг гэсэн бодомжтой олонх нь санал нийлсэн байна. Харин шүүхүүд шаардлага хангасан байранд байрладаг бөгөөд ажиллахад хангалттай өрөө, тасалгаа, зай талбай байдаггүй гэж хариулжээ.

Мөн шүүхийн байгууллага дээр оюутнууд дадлага хийхэд шүүгч болон шүүгчийн туслах нь дадлага хийж байгаа оюутанд юм зааж сургах чин хүсэл байдаггүй. Энэ байдлыг өөрчилж дадлага хийх хугацаанд хийгдэх ажлыг өдөр




өдрөөр нь төлөвлөн дадлага удирдаж буй хүндээ танилцуулна. Тухайн өдөрт хийсэн бүх ажлыг орой нь дүгнэн бичих зэрэг дадлагын удирдамжийг нэгдсэн нэг төлөвлөгөөтэй болгох хэрэгтэй.

График 105. Шүүхийн Тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаагүй оюутнуудын хувьд: n=23




Шүүхийн Тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаагүй оюутнуудын хувьд шүүгчдийн хувьд цалин хөлс нь бусад орлогын эх үүсвэр ашиглахгүйгээр ажиллаж, амьдрахад нь хүрэлцээтэй, тогтвортой ажиллахад хангалттай байдаг гэсэн бодомжтой олонх нь санал нийлж байна.

График 106. Шүүхийн тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаагүй оюутнуудын хувьд: шүүхийн удирдлага, Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн Ерөнхий газар (ШШГЕГ) холбоотой дараах асуудлуудад өөрийн үнэлгээг өгнө үү. n=23



Шүүхийн тамгын газарт мэргэжлийн болон үйлдвэрлэлийн дадлага хийж байгаагүй оюутнуудын хувьд: шүүхийн удирдлага, ШЕЗ болон ШШГЕГ холбоотой үйл ажиллагаа, зохион байгуулалтад олонх нь хангалттай сайн гэсэн үнэлгээг өгсөн байна.

График 107. Та шүүхийн үйл ажиллагаа болон шүүгч нартай холбоотой мэдээллийг хэр их хангалттай мэдээлэл авдаг вэ?



Нийт оюутнуудын олонх нь шүүхийн үйл ажиллагаа болон шүүгч нартай холбоотой мэдээллийг заримдаа л авдаг гэж хариулсан байна.



ДҮГНЭЛТ

Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн явцад тулгарч буй асуудлуудыг тодорхойлж, тухайн асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, бодлогын түвшинд шинэчлэл хийн улмаар шүүх эрх мэдлийн шинэтгэлийн үр нөлөөг тандах зорилгоор зорилтод 7 бүлгээс судалгааг авч судалгааны хүрээнд дүгнэлт, санал зөвлөмжийг гаргав.

Судалгаанд 2023 оны 08 сарын 30-ны өдрөөс 2023 оны 09-р сарын 12-ны өдөр нийт 1,583 хүн судалгаанд хамрагдсан байна. Үүнээс 193 шүүгч, 90 экспертүүд (өмгөөлөгч, прокурор, хуульч болон ИДС-ийн багш нар), 639 шүүхийн захиргааны албан хаагч, 177 шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгч, шүүхэд хандаж байсан 282 иргэн, шүүхэд хандаж байгаагүй 167 иргэн, эрх зүйн ангийн 35 оюутан хамрагдсан байна.

Судалгааны зорилтот 7 бүлгээс 3 бүлэг шүүхийн шинэтгэлийн үр дүнг хэрхэн үнэлж буйг харахад шүүгч нар, шүүхийн захиргааны ажилчид хэрэгжилт сайн гэсэн бол харин прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нар хэрэгжилт муу гэж олонх нь дүгнэсэн байна.

Шүүхийн шинэтгэл

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа үндсэн 5 ажлаас шүүхийн зохион байгуулалтыг Үндсэн хуульд бүрэн нийцүүлсэн болон шүүхийн цахимжилтын ажил хамгийн үр дүнтэй хэрэгжиж байна.

Харин шүүгч нар шүүгчийн ажлын ачааллыг тооцсон жишиг шалгуурыг оновчтой тогтоох хүрээнд хийгдсэн ажил, шүүхийн захиргааны ажилчдын нийгмийн баталгааг хангах болон шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг оновчтой тогтоосон зэрэг ажлын хувьд үр дүнгүй байна гэжээ. Тус 3 ажлын хэрэгжилт муу байгаа шалтгааныг тус бүрээр харуулав. Үүнд:

- Шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаанаас бодлогын түвшинд сайн боловсруулагдаагүй гэж нэн тэргүүнд шүүгчийн ажлын ачааллыг тооцсон жишиг шалгуурыг нэрлэж байна. Тус жишиг шалгуурыг тооцохдоо бодит нөхцөл байдлыг харгалзаж үзээгүй. Нийслэлийн болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг ялгаатай тогтоох, эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоогоор бус шүүгчийн хүлээн авч буй бүхий л хэргийг ажлын ачаалалд оруулж авч үзэх шаардлагатай. Шүүгчийн ажлын ачааллыг тооцох шалгуурыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна гэжээ.
- Шүүгч, шүүхийн захиргааны болон үйлчилгээний ажилчдын цалин хөлс хангалтгүй, нийгмийн баталгаа байхгүй, шүүгчийн туслахууд бусдад доромжлуулах асуудал их гардаг. Залуу ажилчдын хувьд ажлын байран дахь орчин болон хувь хүний амьдрах /орон байр, унаа г.м/ орчин нөхцөл сайжрахгүй байгаа нь ажиллах урам зоригийг мохоох мөн гэр бүлтэй ажилчдын хувьд хүүхдийн боловсрол, чанартай хоол хүнсээр хангагдах наад захын хэрэгцээнд өрхийн санхүү нь хүрэлцэхгүйгээс ажлаас халшрах



асуудал үүсэж байна. Иймд шүүхийн захиргааны ажилчид ялангуяа нийслэлд маш их илүү цагаар ажиллах нөхцөл байдал үүсдэг тул илүү цагийн хөлс, эсхүл ажлын ачаалал тооцсон үзүүлэлт урамшууллыг бий болгох шаардлагатай байна.

- Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг оновчтой байдлын хувьд шүүн туслах ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулахад ШЕЗ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байна гэжээ.
- Прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нар шүүх эрх мэдлийн байгууллагуудын шинэчлэлийг үр дүнгүй гэж үнэлсэн шалтгаан нь 1-рт шинээр томилогдон ажиллаж байгаа шүүгчдийн мэдлэг, ажлын ур чадвар муу, 2-рт хүний нөөцийн орон тооны асуудлаас үүссэн ажлын ачааллаа шийдэж чаддаггүй, 3-рт хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай, 4-рт шүүхийн байгууллага олон нийтэд хаалттай хэвээр байсаар байна гэжээ. Мөн шүүгч нар ёс зүйн, хүний эрхийн мэдрэмжгүй асуудал гаргадаг байна.

Сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагын үйл ажиллагаа

- Шүүгч нарын үзсэнээр өөрчлөгдөөгүй гэсэн бол Шүүхэд хандаж байсан иргэд болон шүүх хуралдааны иргэдийн төлөөлөгчдийн хувьд сүүлийн 2 жилийн хугацаанд шүүхийн байгууллагын үйл ажиллагааг сайжирсан гэж дүгнэж байна.
- Харин байгууллага тус бүрээр харвал Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагаа шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанаас илүү их сайжирсан байна.
- Шүүхэд ажилласан жилээр харахад 1 жил хүртэл болон 4-6 жил ажилласан шүүгч нарын хувьд шүүхийн ерөнхий зөвлөлийг сайжирсан гэж үзсэн шүүгч олонх байгаа бол 1-3 жил ажилласан шүүгч нар Монгол Улсын дээд шүүхийг илүү сайн ажиллаж байна гэжээ. Харин 7 жилээс дээш ажилласан шүүгч нар Монгол Улсын дээд шүүх болон шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааг сайжирсан гэсэн байна.

Шүүгчийн ёс зүй ба хариуцлага, хараат бус байдлын хувьд

- Шүүгчид хэрэг, маргааныг зохих ёсоор шийдвэрлэхэд шаардлагатай мэргэжлийн ур чадвар, хууль, эрх зүйн мэдлэг хангалттай сайн гэжээ. Харин хараат бус байдлын хувьд хангалтгүй гэсэн байна.
- Манай улсын шүүхийн байгууллагууд тодорхой хэмжээгээр авлигад өртдөг бөгөөд аль шатны байгууллага авлигад өртөж байгааг тодруулахад прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нар давж заалдах шатны шүүх илүү авлигатай гэжээ. Харин шүүхийн захиргааны ажилчид, шүүхэд хандаж байсан иргэд, шүүхэд хандаж байгаагүй, оюутан болон ШХИТ-ийн хувьд Монгол Улсын дээд шүүх илүү авлигатай гэжээ.



Шүүхийн захиргааны ажилчдын харилцаа хандлага:

- ШХИТ: Шүүгчийн туслах, ШХНБД болон шүүгч нарын харилцаа, хандлага эелдэг, уриалгахан байсан гэсэн бол МЛМ, ШТГД, Эвлэрүүлэн зуучлагч болон эвлэрүүлэн зуучлагчийн туслахтай харилцаж байгаагүй тул харилцаа хандлагыг хэлж мэдэхгүй байна гэжээ.
- Шүүхэд хандаж байсан иргэнийн хувьд шүүхийн ажилтнуудын харилцааны соёл сайн гэжээ эвлэрүүлэн зуучлагч болон шүүхийн Тамгын газрын дарга нараас бусад МЛМ, шүүгчийн туслах, ШХНБД, шүүгч нарын харилцаа, хандлага сайн гэсэн үнэлгээ авсан байна.

Шүүхийн эрх хэмжээ, бие даасан байдал

- Шүүгч нар ШЕЗ шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчдийн эрх, ашгийг хамгаалах чиг үүргээ зарим талаараа хангалттай сайн хэрэгжүүлдэг гэсэн бол прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нар хангалтгүй хэрэгжүүлдэг гэжээ.
- Шүүгч нар ШЕЗ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, улс төрчид болон бусад аливаа этгээдээс хараат бусаар байдлыг сайн хангаж ажилладаг гэсэн бол прокурор, өмгөөлөгч, хуульч болон хууль зүйн сургуулийн багш нар хангалтгүй хэрэгжүүлдэг гэжээ.
- Шүүхийн нээлттэй ил тод байдлын хувьд хангалтгүй бөгөөд олон нийтийг хууль эрх зүйн мэдээллээр хангахын тулд ямар хэлбэрээр түгээх нь илүү оновчтой, үр дүнтэй, хүртээмжтэй аргын хувьд хандалт өндөртэй сошиал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх, шүүхийн байгууллагын албан ёсны сайтыг идэвхтэй байлгах болон хууль эрх зүйн анализ нэвтрүүлгийг тогтмол хийх нь хамгийн үр дүнтэй аргуудын нэг гэжээ.

Нийт шүүгчдийн чуулганаар хэлэлцэх ёстой асуудал

- Шүүгчийн цалин хөлс, урамшууллын талаар хуульд өөрчлөлт оруулах, төрийн албаны бусад нэмэгдлүүдийг олгодог болгох мөн шүүгчийн нийгмийн баталгаа, шүүхийн захиргааны ажилчдын нийгмийн баталгаа хангах, шүүгчид зэрэг дэвийн нэмэгдэл олгох. Орон нутагт томилогдон ажиллаж байгаа шүүгч нарын эрүүл аюулгүй орчинд амьдрах боломж нөхцөлөөр хангахуйц зай талбайтай, эрүүл, цэвэр орон сууцны асуудлаар хэлэлцэх шаардлагатай байна.
- ШЕЗ-ийн гишүүдийн анх дэвшүүлсэн зорилт, мөрийн хөтөлбөрөөс хэрэгжсэн үйл ажиллагаа, үр дүнгийн талаар хэлэлцэх. Мөн ШСХ-ны үйл ажиллагаа, жилийн тайланг хэлэлцэх.
- Түүнчлэн ШТХ-д Сахилгын зөрчил гэж заасан заалтуудыг мэргэжлийн хариуцлага, сахилгын хариуцлагаар нь ялгаж салгах талаарх хуулийн өөрчлөлтийг хэлэлцэж, шүүхийн сахилгын хороо түүнд итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх хэрэгтэй байна.



Шүүхийн дэд бүтэц, нөөц

- Шүүгч нар шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдын хүрээнд хүний нөөцийн орон тооны асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх хэрэгтэй гэсэн байна. Удаах нь шүүхийн шинэтгэлийн тухай хуулийг дахин харах түүнчлэн удирдах түвшний болон захиргааны ажилчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.
- Жил ирэх тусам нэмэгдэж байгаа хэргийн тоо, хэргийн оролцогч, хавтасны тоо олон мөн олны анхаарлыг зориудаар татсан, хэвлэл мэдээллийн сувгаар урьдчилан мэдээлэгдсэн хэргүүд болон хууль эрх зүйн мэдлэг, өмгөөлөх эрхээр хангагдаагүй этгээдүүдийн хоорондын маргаан ачаалал их үүсгэдэг. мөн шүүх хуралдаан хойшлох болон сахилгын хороонд бичсэн өргөдөл бүрийг хүлээн авч хэрэг үүсгэж, шийдвэрлэж байгаа нь хэрэг шийдвэрлэх хугацаанд нөлөөлж зохиомол ачаалал үүсгэж байна.
- Шүүхийн захиргааны удирдлагуудын ажлын ур чадвар болон харилцааны ур чадваруудад сайн гэсэн үнэлгээ дийлэнх хувийг эзэлж байна.

Шүүхийн нээлттэй ил тод байдал

- Судалгаанд оролцогчдын олонх нь шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд зарим талаараа нээлттэй байдаг гэжээ.

Шүүх нь иргэдийн үндсэн хуулиар олгогдсон эрхийг хамгаалж чадаж байгаа эсэх

- Шүүхэд хандаж байсан иргэдийн хувьд тэдний үндсэн хуулиар олгогдсон эрхийг шүүх муу хамгаалж байна гэсэн бол шүүхэд хандаж байгаагүй иргэд дунд зэрэг хамгаалж байна гэжээ.

Сүүлийн 2 жилд шүүхэд итгэх иргэдийн итгэлийн өөрчлөлт

- Шүүгч нар иргэдийн шүүхэд итгэх итгэл дордсон гэж үзэж байгаа бол ШХИТ-өөр ажиллаж байсан иргэдийн итгэл сайн байна. Мөн шүүхэд хандаж байсан 282 иргэний 226 иргэнийн шүүхэд итгэх итгэл хэвийн буюу ямар нэгэн асуудал үүсэхэд шүүхэд хандана гэсэн бол 56 иргэний шүүхэд итгэх итгэл буурсан байна.
- Шүүхэд итгэх итгэл буурахад шүүгчийг шударга бусаар хэргийг шийдвэрлэсэн гэсэн хардлага болон шүүгчийн харилцаа хандлага нөлөөлдөг байна.
- Шүүхэд хандаж байсан иргэдийн 21 хувь нь шүүхэд хандахад тодорхой хэмжээгээр хүндрэл бэрхшээл үүсэж байсан бөгөөд санхүүгийн хүндрэл бэрхшээл, цахимаар шүүхийн хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой мэдээлэл хязгаарлагдмал, цаг хугацаа их зарцуулдаг зэрэг асуудлууд үүсдэг байна.
- Иргэдийг эрх зүйн мэдээллээр хангахын тулд хандалт өндөртэй социал сувгаар хууль эрх зүйн мэдээллийг тогтмол түгээх, шүүхийн байгууллагын



албан ёсны сайтыг сайжруулах болон шүүхийн тоймыг тогтмол хүргэх ажлыг хийх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ

- Шинээр томилогдож байгаа шүүгч нарын ажлын ур чадвар сул байгаа нь ШЕЗ шүүгчийн ажил мэргэжилд яг таарч тохирох хуульчийг сонгон шалгаруулж чадахгүй байгаатай холбоотой. Цаашид энэ хэвээрээ байвал мэдлэг чадваргүй, хуульчдын дунд хүлээн зөвшөөрөгдөөгүй, ашиг сонирхлын зөрчилд орох шүүгчдийн тоо ихсэх болно. Мөн шүүгчийн туслахуудыг шүүгч болгодог системээ өөрчлөхгүй бол явж ирсэн муу жишиг, шүүгч нараасаа сурсан муу арга өөрчлөгдөхгүй гэж судалгаанд оролцогч нар санал бодлоо илэрхийлсэн байна.
- Шүүгчийн сахилгын зөрчлийг шалган шийдвэрлэх хараат бус, нээлттэй тогтолцоог сайжруулах шаардлагатай.
- Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах үр дүн механизм, нөөц бололцоо болон шаардлагатай үед шүүгч болон түүний гэр бүлийг гишүүдийн хувийн аюулгүй байдалтай холбоотой ажлууд дээр анхаарч ажиллах хэрэгтэй.
- Шүүгч нарын ажлын гүйцэтгэл болон сайн шүүгчийн шилж сонгох нөхцөлийг бүрдүүлэхийн тулд шүүгчийн цалинг нэмэх, цалин, урамшууллын системийг сайжруулах хэрэгтэй байна.
- Шүүгчид сахилгын зөрчилд орохоос урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг хэрхэн дагаж мөрдөх талаарх заавар, зөвлөмж, аргачлалыг илүү сайжруулах шаардлага бөгөөд шүүгч нарын эрх ашгийг хангах талаар судалгаа, шинжилгээ хийх нь зүйтэй.
- Шүүгч нар шүүхийн байгууллагын удирдах болон захиргааны ажилчдын хүрээнд хүний нөөцийн орон тооны асуудлыг нэн яаралтай шийдвэрлэх хэрэгтэй гэсэн байна. Удаах нь шүүхийн шинэтгэлийн тухай хуулийг дахин харах түүнчлэн удирдах түвшний болон захиргааны ажилчдын мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна гэжээ.